

**ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 10 дугаар сарын 21-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-38

1.Ахмад настны тэтгэврийг нэмэгдүүлэх, тэтгэврийн зээлийн хүүг бууруулах, эрүүл мэндийн болон асрах үйлчилгээг сайжруулах талаар иргэдээс ирүүлсэн өргөдлийг судлан үзэж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт 4-32

2.Байнгын хорооны дотоод зохион байгуулалтын талаар танилцуулах 32-38

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Өргөдлийн байнгын хорооны
10 дугаар сарын 21-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Өргөдлийн байнгын хорооны дарга О.Номинчимэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 24 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 54.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 33 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: С.Замира;

Тасалсан: Д.Батбаяр, Х.Баттулга, Б.Батцэцэг, С.Ганбаатар, С.Цэнгүүн, Р.Эрдэнэбүрэн.

Нэг.Ахмад настны тэтгэврийг нэмэгдүүлэх, тэтгэврийн зээлийн хүүг бууруулах, эрүүл мэндийн болон асрах үйлчилгээг сайжруулах талаар иргэдээс ирүүлсэн өргөдлийг судлан үзэж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, мөн яамны Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын газрын дарга Б.Алимаа, Нийгмийн даатгал, хуримтлалын бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, Төсөв санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Энхтөр, Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Ю.Отгонбилэг, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга М.Наранпүрэв, Монголбанкны Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын Эрсдэлийн үнэлгээний хэлтсийн захирал Г.Борхүү, мөн банкны Мөнгөний бодлогын газрын Макро зохистой бодлогын хэлтсийн дарга М.Батболд, Хууль, эрх зүйн газрын Банк, санхүүгийн эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн М.Батсайхан, Хууль, эрх зүйн хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Солонго, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Нармандах, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, мөн газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг, Хаан банкны Бизнес хөгжил хариуцсан дэд захирал С.Энх-Ирээдүй, Худалдаа хөгжлийн банкны гүйцэтгэх захирлын орлогч П.Мөнхнаст, Төрийн банкны Хууль, эрх зүй хариуцсан дэд захирал Б.Амарсанаа, Монголын ахмадын холбооны ерөнхийлөгч Ц.Сүхбаатар, Өргөдөл гаргагч иргэдийн төлөөлөл Ц.Алтанзул нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын зөвлөх Б.Мажигсүрэн, мөн газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Д.Наранцэцэг, референт Г.Нямсүрэн нар байлцав.

Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат танилцуулав.

Санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Л.Мөнхбаясгалан, Ж.Галбадрах, Д.Ганмаа, О.Номинчимэг нарын тавьсан асуултад Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Д.Эрдэнэбат, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Монголбанкны Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын Эрсдэлийн үнэлгээний хэлтсийн захирал Г.Борхүү, мөн банкны Мөнгөний бодлогын газрын Макро зохистой бодлогын хэлтсийн дарга М.Батболд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, Хаан банкны Бизнес хөгжил хариуцсан дэд захирал С.Энх-Ирээдүй, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга М.Наранпүрэв, Өргөдөл гаргагч иргэдийн төлөөлөл Ц.Алтанзул нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа, Б.Бат-Эрдэнэ, Г.Лувсанжамц, Б.Пунсалмаа, Ч.Ундрэм, О.Номинчимэг, Л.Мөнхбаясгалан нар үг хэлэв.

О.Номинчимэг: Ахмад настны тэтгэврийг нэмэгдүүлэх, тэтгэврийн зээлийн хүүг бууруулах, эрүүл мэндийн болон асрах үйлчилгээг сайжруулах талаар иргэдээс ирүүлсэн өргөдлийг судлан үзэж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг зарчмын хувьд дэмжиж, Хүний хөгжил, нийгмийн бодлогын болон Төсвийн байнгын хороонд уламжлах нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 3

Бүгд: 16

81.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Өргөдлийн байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат Хүний хөгжил, нийгмийн бодлогын болон Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны дотоод зохион байгуулалтын талаар танилцуулах

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын зөвлөх Б.Мажигсүрэн, мөн газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Д.Наранцэцэг, референт Г.Нямсүрэн нар байлцав.

Байнгын хорооны дарга О.Номинчимэг Байнгын хорооны дотоод зохион байгуулалтын талаар танилцуулав.

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороонд ирүүлсэн өргөдөл, гомдлын тоймыг Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Д.Наранцэцэг танилцуулав.

Байнгын хорооны дотоод зохион байгуулалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, Г.Лувсанжамц нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга О.Номинчимэг, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Д.Наранцэцэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ үг хэлэв.

Уг асуудлыг 11 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 02 минут үргэлжилж, 24 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 70.8 хувийн ирцтэйгээр 11 цаг 35 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

О.НОМИНЧИМЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 10 дугаар сарын 21-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
09 цаг 33 минут.

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

О.Номинчимэг: Байнгын хорооны эрхэм гишүүддээ өглөөний мэнд хүргэе.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Өргөдлийн байнгын хорооны 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Өргөдлийн байнгын хорооны өнөөдрийн хуралдаанд Бат-Өлзийн Бат-Эрдэнэ ирсэн байна. Даваасамбуугийн Ганмаа гишүүн ирсэн байна. Ганзоригийн Лувсанжамц гишүүн ирсэн байна. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн ирсэн байна. Жамбын Батсуурь гишүүн ирсэн байна. Хажекберийн Жангабыл гишүүн ирсэн байна. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн ирсэн байна. Дүгэрийн Рэгдэл гишүүн ирсэн байна. Жанчивын Галбадрах гишүүн ирсэн байна. Жаргалсайханы Золжаргал гишүүн ирсэн байна. Пүрэвбаатарын Мөнхтулга гишүүн, Мягмардашийн Сарнай гишүүн, Одсүрэнгийн Номинчимэг нар ирсэн байна.

Байнгын ирц 54.2 хувьтай. Ирцийг танилцуулж дууслаа. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. Өнөөдөр 2 асуудал байгаа.

Нэгдүгээр асуудал бол ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэх асуудал.

Өргөдлийн байнгын хорооны 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор батлагдсан ахмад настны тэтгэвэр нэмэгдүүлэх, тэтгэврийн зээлийн хүүг бууруулах, ахмадуудад зориулсан эрүүл эрүүл мэндийн болон асрах үйлчилгээг сайжруулах асуудлаар судлан үзэж санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг танилцуулж хэлэлцэхээр байгаа.

Хоёрдугаар асуудал, Өргөдлийн байнгын хорооны дотоод зохион байгуулалтын талаар буюу Байнгын хороо шинээр байгуулагдсанаас хойш ирсэн өргөдөл, гомдлын талаарх мэдээлэл болон Байнгын хорооны ажиллах дүрмийн талаар танилцуулж санал солилцохоор энэ 2 асуудал байгаа.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байна уу?

Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё. Нэгдүгээр асуудал ажлын хэсгийн санал, дүгнэлт.

Та бүхэнд өнгөрсөн долоо хоногт ажлын хэсгийн санал, дүгнэлтийг тараасан байгаа.

Ахмадын дуу хоолой хөдөлгөөний ахмадууд, ахмадуудын зөвлөлийн төлөөлөл Ц.Алтанзул нарын иргэдээс ирүүлсэн шаардлагыг Өргөдлийн байнгын хороо 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд Байнгын хорооны 1 дүгээр тогтоолоор ахмадын тэтгэвэр нэмэгдүүлэх, тэтгэврийн зээлийн хүүг бууруулах, ахмадуудад зориулсан эрүүл мэндийн болон асрах үйлчилгээг сайжруулах талаар судлан үзэж санал, дүгнэлтийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан.

Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг, ажлын хэсгийг Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн ахалж, Дүгэрийн Рэгдэл гишүүн, Пүрэвбаатарын Мөнхтулга гишүүд нар орж ажиллаж бас нэлээдгүй төрийн байгууллагуудтай уулзаж, санал солилцож санал, дүгнэлтээ гарсан гаргасан байгаа.

Ажлын хэсгийг оруулъя. Ажлын дэд хэсэг буюу албан тушаалтнуудыг хуралдаанд оруулъя. Ажлын дэд хэсэг маань орчих. Дараа нь энэ асуудлыг угаасаа Нийгмийн бодлогын байнгын хороо, Төсвийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаар хэлэлцүүлж төсөвт суулгах, яг төсөв хэлэлцэж байгаа энэ үед суулгах талаар байгаа. Тэгэхээр өнөөдөр Өргөдлийн байнгын хорооноос байгуулсан ажлын хэсэг маань яг энэ төсөв дээр суулгах саналуудаа өнөөдөр нарийвчилж ярих ёстой байгаа.

Ажлын хэсгийн албан тушаалтнууд, оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Л.Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга. Ирсэн үү Мөнхзул дарга? Ажлын хэсгийн Мөнхзул дарга ирсэн байна. Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ц.Сүхбаатар Монголын ахмадын холбооны Ерөнхийлөгч ирсэн үү? Ирчихсэн. Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Энх-Амгалан, Л.Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Б.Алимаа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн эрхлэлтийн бодлогын газрын дарга, В.Рэнцэнханд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын бодлогын газрын дарга, Ж.Энхтөр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төсөв санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Ю.Отгонбилиг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга, М.Наранпүрэв Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Д.Отгонбаатар Эрүүл мэндийн яамны Эрүүл мэндийн даатгалын Бодлого зохицуулалтын газрын дарга, Б.Батжаргал Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга. Батжаргал дарга ирсэн байна. Нармандах Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Борхүү Монголбанкны Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газар Эрсдэлийн үнэлгээний хэлтсийн захирал, Батболд Монголбанкны Мөнгөний бодлогын газрын Макро зохистой бодлогын хэлтсийн дарга, Ганцэцэг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга, М.Батсайхан Монголбанкны Хууль, эрх зүйн газрын Банк, санхүүгийн эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн. Арилжааны банкны төлөөлөл бас энэ өнөөдрийн хуралдаанд ирсэн байна. Мөнхнаст Худалдаа хөгжлийн банкны Гүйцэтгэх захирлын орлогч, Энх-Ирээдүй Хаан банкны Бизнес хөгжил хариуцсан дэд захирал, Амарсанаа Төрийн банкны Хууль, эрх зүй хариуцсан дэд захирал, Солонго Монголбанкны Холбооны хууль, эрх зүйн хамтын ажиллагаа хариуцсан

ахлах менежер, Төр-Энх Төрийн банкны Бизнес бодлогын төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн ирсэн байна. Өргөдөл гаргасан иргэдийн төлөөллөөс Ц.Алтанзул өргөдөл гаргагч иргэн ирсэн байна. Баярлалаа.

Ингээд ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Сүхбаатарын Эрдэнэбат гишүүнийг танилцуулна уу гэж урьж байна. Микрофон өгье.

С.Эрдэнэбат: Өргөдлийн байнгын хорооноос миний биеийг ахлуулаад Улсын Их Хурлын гишүүн Рэгдэл, Улсын Их Хурлын гишүүн Мөнхтулга бид 3 энэ ахмадын тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлэх, мөн ахмадын зээлийн хүүг бууруулах, зээлийн хязгаарлалтыг хуучин хэвэнд нь оруулах, мөн ахмадын эрүүл мэнд, үйлчилгээ, асрах, сувилах үйлчилгээг сайжруулах гэх мэтчилэн 6 зүйл санал, шаардлага бүхий өргөдлийг судалж Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монголбанк, арилжааны банкнууд, мөн Эрүүл мэндийн яам, Ахмадын холбоо, ахмадуудын өргөдөл гаргасан Алтанзул тэргүүтэй ахмадууд, мөн бусад холбогдох төрийн байгууллагуудын ажилтан, албан хаагч нартай уулзаж, удирдлагуудтай уулзаж өргөдлийн талаар мэдээ, мэдээллүүдийг тодруулсан.

Тэгээд хамгийн гол ахмадуудын тавьж байгаа нэгдүгээр шаардлага тэтгэврийн доод хэмжээг сая 500 болгох гэдэг ийм шаардлага байгаа. Тэгэхээр ажлын хэсэг энэ тэтгэврийг сая 500 мянган төгрөг болгоход тодорхой Сангийн яам болон бусад газруудаас 3.4 орчим их наяд төгрөг хэрэгтэй учраас санхүүгийн хувьд боломжгүй гэдэг нэгдүгээрт ийм саналыг бол өгсөн.

Хоёрдугаарт, ахмадууд маань хамгийн доод талын тэтгэврүүдийг нэмчихээр шударга бус байна. Өндөр тэтгэвэр авч байгаа сая 500 буюу түүнээс дээш тэтгэвэр авч байгаа хүмүүсийн хувьд нэмэгдэлгүй хоцрох юм байна гэдэг ийм саналыг бас өгсөн. Тийм учраас ажлын хэсэг ер нь энэ тэтгэврийн хэмжээг амьжиргааны баталгаажих доод түвшин хувь 1 хүнд 500 орчим мянган төгрөг одоо бол байгаа. Тэгэхээр энэ тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлэх асуудал хаанаас үүдэлтэй вэ гэдэг энэ асуудлыг судалж үзээд ер нь ахмадууд амьжиргааны баталгаажих доод түвшин буюу түүнтэй ойролцоо тэтгэвэр ихэвчлэн авдаг.

Тийм учраас энэ тэтгэврийнхээ доод хэмжээ буюу нийт ахмадуудын 92 хувь нь сая 500 мянган төгрөгөөс доош тэтгэвэр авч байгаа юм. Тийм учраас нийт ахмадуудын сая 500 мянган төгрөгийг хүргэх нь нийт ахмадуудын 92 хувьд хүрч үйлчлэх учраас цаашдаа энэ сая 500 мянган төгрөгийг Улсын Их Хурал, Засгийн газар өөрийн бүрэн эрхийн энэ хугацаанд жил болгон дорвитой, бодитоор нэмэгдүүлэх шаардлагатай гэж дүгнэсэн.

Өнөөдрийн байдлыг хүртэл сүүлийн 10 жилээр авч үзэх юм бол тэтгэврийг 2016 онд нэмэгдээгүй, 17 онд нэмэгдээгүй, 18 онд 27 мянгаар, 19 онд 24 мянгаар, 20 онд 25-40 мянган төгрөгөөр, 22 онд 15-43 хувиар, 23 онд 10-22 хувиар, 24 онд 100 мянган төгрөгөөр бүгд жигд, 25 онд 6 хувиар, 26 онд одоогийн байгаа төслөөр 6 хувиар гэдэг байдлаар хувиар оруулж ирсэн.

Энэ дээр Их Хурлын гишүүд болон нэгдсэн чуулган дээр ямар маргаан, байр сууриуд гарсан бэ гэхээр одоогийн ахмадуудын тэтгэврүүд тогтоосон хэмжээ нь яг шударга буюу өөрийнхөө төлж байсан юунаас хамаарч байгаа юу, үгүй юу гэдэг дээр судалгаа хийсэн. Ингээд үзэхээр 170 орчим мянган хүн тэтгэвэр авч байгаа ахмадууд тэтгэврийн хэмжээг тогтоохдоо авч байсан цалингийнх нь дээд

итгэлцүүр гэдэг буюу түүнийг нь хязгаарлаж тогтоосноос болоод 170 орчим мянган хүн яг бодит авах тэтгэврээсээ доогуур авч байгаа гэсэн ийм судалгаа гаргасан. Тэгэхээр үндсэндээ нийт ахмадуудын гуравны нэг орчим нь тэтгэврээ шударгаар тогтоолгож чадаагүй, багаар тогтоолгосон гэж. Тэгэхээр энийг цааш нь нэмэгдүүлэх, зөрүүг нь арилгах асуудлыг энэ Ахмадын холбоо ч өмнө нь тавьж байсан. Одоо ч гэсэн ахмадууд тавьж байгаа. Ахмадууд тавьж байгаа. Тийм учраас мөн дээрээс нь жилд 3000 орчим ахмадууд сүүлийнхээ 5 жилийг хамгийн өндрөөр огцом нэмж төлөх ийм зүйлээс болж тэтгэврийн зөрүү бас нэлээн зөрүүтэй тогтоох ийм эрсдэл хуулийн цоорхой үүссэн байна гэдэг ийм дүгнэлтийг гаргасан.

Тийм учраас товчхондоо хэлэхэд одоогийн ахмадын тэтгэврүүд харилцан адилгүй бүгд яг авч байсан итгэлцүүр, томьёоллоороо авч байсан цалингаараа ижилхэн тогтоолгож чадаагүй юм байна. Тийм учраас бүгдийг нь жигд нэмнэ. Жигд хувиар нэмнэ гэдэг нь өөрөө өрөөсгөл юм байна. Тэгэхээр ер нь ойрын хугацаанд ахмадын тэтгэврийн зөрүүг энэ ялгаатай байдлаар цаг үеэсээ байдлаар ялгаатай тогтоосон энэ зөрүүнүүдийг нь арилгах шаардлагатай юм байна. Үүнд нь ойролцоогоор бараг 150-аад тэрбум төгрөг хэрэгтэй юм байна зөрүү арилгахад. Тийм учраас энийг арилгасны дараа харин жигд инфляцынхаа түвшинтэй уялдуулаад нэмэгдүүлэх нь зүйтэй. Түүнээс нааш холимог мөнгөн дүнгээр нэмбэл яасан юм бэ гэдэг ийм саналыг гаргасан.

Та бүгдийн анзаарч байгаа байх. Сүүлийн 10 жилд ч гэсэн хувь, мөнгөн дүн, хувь, мөнгөн дүн гэдэг байдлаар сөөлжих байдлаар яваад сүүлийн 3 жил, 2 жилд нь болохоор хувиар нэмээд, 1 жилд нь болохоор жигд мөнгөн дүнгээр нэмсэн ийм зүйл байгаа.

Тийм учраас инфляцын түвшинд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 10.3 хувиар нэмэгдүүлье гэдэг саналыг өгсөн байна. Энэ юу вэ гэхээр энэ жилийн инфляцын хүлээгдэж байгаа мөнгөний бодлого буюу төсвийн хүрээний мэдэгдэлд 9.5 хувь гэж өгсөн. Одоогийн байдлаар 8.8, Улаанбаатарт 10 гаран хувьтай байгаа. Оны сүүлээр аваад үзэх юм бол хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр энэ инфляцын түвшин 10 хувь руу дөхөх нь илүү бодит байдал руу ойртох ийм тоо юм байна гэдэг байдлаар үзэж, мөн дээрээс нь энэний өмнөх жил нэмсэн 6 хувь гэж байгаа. Нийгмийн даатгалын хуулиар хамгийн доод тал нь 6 хувь буюу инфляцын түвшнээсээ дээш нэмэгдүүлнэ гэдэг байдлаар хуульд өөрчлөлт оруулсан.

Тийм учраас энэ жилийн нэмэгдэл буюу өнгөрсөн жилийн төсөвт сууснаар одоогийн байдлаар 6 хувь байгаа нь өнгөрсөн жилийнхээ инфляцаас хоцрогдолтой нэмэгдсэн. Ингээд ер нь 0.8 гэж үзээд 10.3 гэдгээс төсөвт санал өгсөн байгаа. Тэгэхээр одоогийн байдлаар ирэх жилийн, энэ жилийн инфляцыг 6 хувь гэж байгаа нь нийгмийн даатгалын хуулийг нийцээгүй байна. Өөрөөр хэлбэл инфляцын түвшнээсээ доогуур байна. Тийм учраас хамгийн доод тал нь инфляцын түвшнээс дээшээ нэмэгдүүлэх ёстой. Бодитоор нэмэгдүүлье гэх юм бол инфляцын түвшин дээр нэмэх нь мөнгөн дүн гэдэг, хувь гэдэг юм уу ийм байдлаар нэмж байж яг бодитоор тэтгэврийг нэмлээ гэж үзнэ.

Тийм учраас ажлын хэсгийн зүгээс одоогийн байгаа хэрвээ нэмбэл хувилбаруудыг санал болгосон. Одоогийн 6 хувийг зайлшгүй нэмэгдүүлэх хэрэгтэй. Зарим хүмүүс 8 хувь, одоо байгаа инфляцаар нэмчихье гэж байгаа юм. Тэгэхээр энэ ер нь оны сүүлийн буюу өнгөрсөн жилийн инфляцын зөрүү болон энэ

жилийн инфляцын зөрүүг нийлүүлээд дор хаяж 10 орчим хувиар нэмэгдүүлэх ийм хэрэгцээ шаардлага байна гэдгийг дүгнэсэн. Тийм учраас энэ дээрээ нэмэгдүүлэхдээ одоогийн байгаа 6 хувь дээрээ нэмэх нь үлдэгдэл нэмж шаардагдах 10.3 хувиар нэмсэн тохиолдолд 267 тэрбум төгрөг нэмэх хэрэгтэй юм байна. Үүнийг нь хамгийн багадаа гэдэг, би хэлье хамгийн багадаа үүнийг нийт ахмадууддаа шударга, жигд хуваачихаар 42 орчим мянган төгрөг байгаа.

Тэгэхээр 6 хувь дээр нэмэх нь 42 хувь гэдэг хамгийн, 42 мянган төгрөг гэдэг бол хамгийн багадаа шүү. Үүнээс дээш нь тэр доод тэтгэврүүдийн илүү нэмэх дахиад хувиудыг нь дээш нь мөнгөн дүнгүүдийг нь дээш нь тухайлбал 10 хувь дээр нэмэх нь 100 мянган төгрөг ч юм уу, 200 мянган төгрөг гэдэг юм уу ийм байдлаар нэмэх нь энэ төсөв, санхүүгийн байдлаас хамаараад нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзсэн гэдгийг хэлчихмээр байна.

Хоёрдугаарт нь ахмадуудын. Тийм учраас төсөв болон бусад ахмадуудын энэ тэтгэврийг нэмэгдүүлэх асуудлыг дараагийн Байнгын хороод дээр энэ тоог анзаарах хэрэгтэй юм байна. Түүнээс биш дундажлаж авч үзээд одоогийн 8 хувь ч гэдэг юм уу, эс үгүй бол 6 хувиар нь хэвээр нь байлгах гэдэг бол хуулийн зөрчилд орох юм байна гэдгийг дүгнэсэн.

Тэтгэврийн зээлийн хүү. Ер нь энэ сая 500 мянган төгрөг болгох энэ шаардлага хаанаас гэнэт гараад огцом шаардлага гарч ирэв гэхээр нэгдүгээрт манай ахмадууд маань 92 хувь нь үндсэндээ үүний бараг талаас илүү хувь нь 692 буюу 700-800 орчим мянган төгрөгийн тэтгэвэр авдаг байх нь. Тэгэхээр үндсэндээ энэ ахмадууд яаж амьдардаг байсан бэ гэхээр үндсэндээ зээлээс зээлийн хооронд. 36 сарын тэтгэврийн зээлийг хэвээр нь үлдээгээч гэдгийн цаана нь одоо шууд бүгдээрээ 36 сарын тэтгэвэр авъя гэдэг ийм байдлаасаа биш, өөрөөр хэлбэл нэгэнт тэтгэврийн зээлийг нь авчихсан үндсэндээ 3 сарыгаа төлөөд, буцааж 3 сарыг нь аваад энэ хязгаар нь бол энэ хязгаар нь тулчихсан байгаа учраас энэ тэтгэврийн зээлийг эргүүлж авч үзэх ийм шаардлага байна гэдгийг хэлмээр байна.

Монголбанкны зүгээс анх Засгийн газар болон Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас санал ирүүлсний дагуу тэтгэврийн зээл нь хязгаарлалт тогтоосон гэж анх шийдвэрээ гаргасан. Энийг бид Нийгмийн бодлогын байнгын хороо болон бусад Их Хурлын гишүүдээс санал, шаардлага, асуудал тавиад эргээд шийдвэрээ цуцаллаа гэсэн.

Тийм учраас ахмадууд эргээд тэтгэврийн зээлийг хэвд нь оруулаач гэж тавьсан. Монголбанк ч гэсэн шийдвэрээ цуцалсан. Одоогийн байдлаар арилжааны банкнууд дээд тал нь 24 сарыг олгож байна. Зээлийн хувийн хувьд тэтгэврийн зээлийн дундаж хэмжээ нь өссөн байна. Сүүлийн энэ наадмаас хойш гэсэн үг. Өссөн байна. Энэ бас Монголбанкны мөнгөний бодлогын хүү болон бусад шалтгаанаас хамааруулаад тавьсан байна. Тийм учраас зээлийн хэмжээг огцом сард биш.../минут дуусав./

О.Номинчимэг: Эрдэнэбат гишүүнд нэмэлт 1 минут өгье.

Д.Эрдэнэбат: Аажмаар энэ тэтгэврийн зээлийг тэр 36 сарыг нь хязгаарлах юм уу энийг аажмаар хийхгүй бол огцом тавьсан тохиолдолд ахмадууд шууд санхүүгийн хүндрэлээ аваачиж байна гэдгийг дүгнэсэн. Тийм учраас Монголбанк, Засгийн газар саналаа татчихсан учраас энэ шийдвэрийг эргэж авч үзээч гэдэг ийм зүйлийг тавьж байгаа.

Дараагийн асуудал нь Монголбанкн дээрээс арилжааны банкнуудтай уулзахад тэтгэврийн зээлийг бууруулахад хэд хэдэн хүчин зүйл байна. Нэгдүгээрт тэтгэврийн зээлийн эргэн төлөлт 97, 8 буюу хамгийн сайн зээлүүдийн ангилалд ордог. Гэтэл эрсдэлийг нь 150 хувь болгоод тавьчихсан тооцчихсон. Хамгийн өндөр эрсдэлтэй зээл гэдэг ангилалд нь оруулчихсан. Тийм учраас Монголбанк энэ зээлийн эрсдэлийг ангилалд энэ хувиа эргэж хараач гэдэг. Хэрвээ ингэх юм бол энэ эрсдэлийг бууруулах юм бол эрсдэлийн сан буураад тэтгэврийн зээлийг бууруулахад тодорхой нөлөөлөл бий болно гэдэг дүгнэлтийг гаргасан.

Хоёрдугаарт заавал байлгах нөөцийн хэмжээг тодорхой уян хатан нөхцөлтэй тэтгэврийн зээлд олгож байгаа эх үүсвэрүүдийг гаргахад заавал байлгах нөөцийн хэмжээг нэмэгдүүлбэл бас зээлийн хязгаар.../минут дуусав./

О.Номинчимэг: Ажлын хэсгийн ахлагч Эрдэнэбатад баярлалаа.

Гишүүдээс угаасаа асуулт, хариулт орохоор тэр үед бас дэлгэрэнгүй энэ санал, дүгнэлтээ яах байх. Та бүхэнд гишүүдэд бас энэ санал, дүгнэлтийг өмнөх долоо хоногт тараасан байгаа болохоор уншиж танилцсан байх гэж бодож байна.

Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан асуух асуулттай, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Цуг юм уу энэ? Ажлын хэсэг буюу Эрдэнэбат гишүүнээс асууж болно. Мөн өнөөдөр ажлын хэсэг гээд төрийн энэ холбогдох байгууллагууд байгаа учраас санал, дүгнэлттэй холбогдуулан энэ хүмүүсээс асууж болно. Нэрсээ өгнө үү. Цуг юм уу? Асуулт эхлээд, асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Ганмаа гишүүнээр тасаллаа. Ирцийн дагуу Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүний микрофон өгье.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Тэгээд ажлын хэсгийн дүгнэлт маань гарсан. Яг алийг гэж та бүхэн маань хувилбар, аль хувилбарыг санал болгож байгаа юм бэ? Яг энэ хувилбараа улс төржилгүйгээр эдийн засгийн нөхцөл байдалтайгаа уяад Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, бусад холбогдох яамнуудтайгаа яриад яг эцэслэсэн хувилбар нь аль юм бэ гэдгийг би нэгдүгээрт асуумаар байна.

Хоёрдугаарт, бид нар өнөөдөр инфляц, бодлогын хүү, зээлийн хүү, эргээд бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт гэдэг зүйлээ харахгүй бол их хэмжээний нэмэгдэл нэг талдаа явдаг, эсвэл тодорхой хэмжээний нэмэгдэл явдаг. Эргээд бараа, бүтээгдэхүүний үнэ ард түмний нуруун дээр ирдэг, эргээд тэр нэмэгдсэн утга учир чинь байхгүй болчих вий дээ. Тийм учраас ийм нөхцөл байдлыг үүсгэхгүй байх хувилбар нь яг та бүхний хувьд аль нь вэ гэдгийг би нэгдүгээрт асуух гэж байгаа юм.

Хоёрдугаарт, ахмадуудаас маань сая 500 мянга доод хэмжээ гээд яриад байна. Ахмадуудын төлөөллийн үгийг би сонсох нь зөв болов уу гэж бодож байна. Ямар үндэслэлээр сая 500 мянга гэдэг дүнг оруулж ирж байгаа вэ? Бас үндэслэл байгаа байх. Тэгээд аль болох бид нар нэмнэ гэдэг тал дээр бол байгаа. Гэхдээ бид нар эргээд ачаалал болохгүй өөрсдийнх нь амьдрал ахуй илүү дордчихгүй байх түвшнийг л их сайн хувилбарыг л их сайн олж сонгох ёстой гэж харж байгаа. Тэгээд ахмадын төлөөллөөс бас үг хэлээч гэж хүсэж байгаа. Тэгээд тэрний дараа тодруулъя. Баярлалаа.

О.Номинчимэг: Эцсийн дүгнэлт, хувилбарын талаар энэ инфляцтай холбогдуулан ямар нөлөөлөх вэ гэдэг талаар хэн хариулах вэ? Эсвэл яг хамгийн боломжит хувилбар гэдгийг хоёр дахь асуулт ахмадын төлөөллийн үгийг сонсьё гэж байна. Өргөдөл гаргагч буюу Алтанзул гуай ирсэн байна. Микрофон, 9 номерын микрофон дээр суугаад сая 500 мянга гэдэг тооны үндэслэлийг та бүхэн хэлж өгөөч гэсэн асуултад хариулах уу? 9 номерын микрофон.

Ц.Алтанзул: Сайн байцгаана уу? Энэ өдрийн амар амгаланг айлтгая. Ингээд Төрийн ордны гадаа 30, бараг 40-өөд хоног ингээд суусан. Суулт хийсэн ихэнх ахмадууд маань биеийн байдал муудсан байгаа. Би өөрөө ингээд бүлцийгээд омбойгоод ингээд сууж байгаа. Сая 500 гэдэг энэ тоо бол ерөөсөө ахмадуудын өөрсдийнх нь юугаар ингэж урган гарсан ийм тоо байдаг юм. Миний байр суурь болохоор 689 мянган төгрөгийн тэтгэвэр авдаг ахмадуудыг 2 дахин тэтгэврийн хэмжээг нь нэмэх боломж байна уу? Тэгээд 572, 689-тэй бага хэмжээний тэтгэвэртэй. Халамжаас тэтгэвэр авдаг ахмадууд маань 7400 ахмад байдаг юм байна. 397500 авдаг. Энэ амьжиргааны доод түвшний 495 мянган төгрөгт хүргэх боломж байна уу? Тэтгэврийг үе шаттай 3 үе шатлалтай нэмнэ гэсэн бол эхний ээлжид 50 хувиар нэмэх тийм боломж байдаг болов уу гэж бодож байгаа. Яагаад гэхээр 281200 байхад маань тэтгэврийн зээлтэй байгаад байгаа байхгүй юу. Тэгээд 3 хоног 24 сараар ингээд зээл олгочихсон байгаа. Үнэхээр хүнд байгаа, бодит амьдрал дээр маш хүнд байгаа.

Тэгээд 1 удаадаа тэтгэврийн зээлийг нь 36 сараар сунгаж өгөөд тэгээд банкныхан ирчихсэн байгаа болохоор энийг ярьж байна л даа. 1 удаадаа 36 сараар сунгаж өгөөд 35 сарын зээл Худалдаа хөгжлийн банк бол аягүй боломжийн юу яадаг юм байна шүү дээ. 24 сараар зээл өгчхөөд 23 сарын зээлийн үлдэгдэлтэй өнжөөчхөөд, 22 сард 1 сар гээд ингээд ингээд явдаг юм байна лээ.

Тэгэхгүй болохоор гар дээрээ юу ч байхгүй ингээд ахмадууд маань амьдрал нь маш хүнд байгаа. Ихэнх нь эмнэлгээр явж байна. Үр хүүхэдгүй ганц бие ахмадууд маш олон байдаг. Эд нарыгаа төр засаг маань 1 удаа харж хандаад ингээд боломжийг олгож өгөөч гэсэн саналыг хэлж байгаа юм. Бүр банкны зээлийн хүүг уул нь болж өгвөл 12 хувьд хүргээд өгөөч гэсэн. Тэр нь ч бүр худлаа л болох байх л даа. Ямар ч байсан тэтгэврийг 26 онд нэмэгдэнэ шүү дээ. Тэр бас цаг ч байна, зай ч байна, лай ч байна. Тэгэхээр эхлээд тэтгэврийн зээлийн асуудлыг нь шийдээд өгөөч гэдэг саналыг л хэлэх гэж орж ирсэн юм.

2 дахин өсгөх санал маань юу вэ гэхээр 689 мянган төгрөгийн тэтгэвэр авдаг тэтгэвэр авагч маань ингээд банкны зээлтэй байгаа шүү дээ. Тэгэхээр ямар ч орлогогүй учраас 2 дахин өсгөж өгөөч гэсэн тоог бол гаргасан юм.

О.Номинчимэг: Ойлголоо эхний асуулт буюу эцсийн дүгнэлт болон инфляцтай холбоотой ямар нөлөөлөл үзүүлэх вэ? Эрдэнэбат гишүүн.

Д.Эрдэнэбат: Би түрүүн хэлсэн хувилбарын хувьд хуулиараа хамгийн доод тал нь бид нар инфляцын түвшнээс дээшээ нэмэх ёстой. Тэгэхээр 2 асуудал яригдаж байгаа. Нэгдүгээрт энэ жилийн нэмсэн 6 хувь чинь өнгөрсөн жилийн инфляцаа гүйцэхгүй буюу бодитоор хоцрогдолтой байна. Энэ жилийн инфляцыг нэмэх нь ирэх жилийн мөнгөн дүндээ нэмээд үзэхээр нийтдээ 10 орчим хувь байгаад байна.

Тэгэхээр холимог хэлбэрээр нэмье. Ахмадын тэтгэвэр тогтоолгосон хэмжээг нь аваад үзэхээр харилцан адилгүй янз бүр байгаад байгаа учраас шууд жигд 6 хувь юм уу, 10 хувь нэмүүлэхэд магадгүй 4 сая төгрөгийн тэтгэвэртэй хүн нь 400 мянга, 600 мянган төгрөгийн тэтгэвэртэй хүн нь 60 мянган төгрөг буюу хоорондынх нь зөрүү улам холдох ийм эрсдэлтэй. Тийм учраас дундын хувилбараар шийдчихвэл яасан юм бэ гэдэг ийм саналыг ажлын хэсгийг санал болгож байгаа юм. Хамгийн доод тал нь шүү. Хамгийн доод тал нь холимог хэлбэрээр.

О.Номинчимэг: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя. 1 минут.

Б.Бат-Эрдэнэ: Яах вэ энэ манай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны л алдаатай бодлого л доо. Ерөөсөө эцсийн үр дагавар. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нэгдсэн бодлогоо барьж явж чадаагүй улс төрждөг. Тэрнээс улбаатайгаар ийм тэтгэврийн ялгамжтай асуудлууд их үүсчихсэн нэг талдаа. 2021 онд Монгол Улсын төсөв 15.6 их наяд, 2022 онд 18.1 их наяд, 2023 онд 22.5 их наяд, 2024 онд 30.5 их наяд, 2025 онд 33.4 их наяд төгрөг болж өссөн. Бараг 2 дахин өсчхөөд байгаа юм. Гэтэл ахмадуудын тэтгэвэр нэмэгдсэн үү? 2021 онд ахмадууд хэдэн төгрөг авч байсан юм тэтгэвэр? Гэтэл улсын төсөв чинь 2025 онд 33.4 их наяд болоод бүүр даблдчихаад байна шүү дээ. Тэр хэмжээгээр ахмадын тэтгэвэр даблдаж чадсан юм уу? Энд ямар бодлогын алдаа гарчхав гэдэг дээр ажлын хэсэг судалгаа хийсэн үү?

О.Номинчимэг: Хэн хариулах вэ? Ажлын хэсгээс манай төрийн байгууллагуудаас Мөнхзул дарга уу? 6 номер Мөнхзул дарга.

Л.Мөнхзул: Эрдэнэбат гишүүн. Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Мөнхзул. 2022 он оны байдлаар тэтгэврийн хэмжээг 15-43 хувиар нэмсэн. Нэмсний дараах тэтгэврийн дундаж хэмжээ 549.5 мянган төгрөг байсан. Нэмэгдэл 637 тэрбум төгрөг тухайн жилд зарцуулсан. 2025 оны байдлаар дундаж тэтгэврийн хэмжээ 848 мянган төгрөг байна. Ингээд тэтгэврийн хэмжээ 20 оноос 25 оны хугацаанд 2 дахин, 2 дахин гаруй нэмэгдсэн байна. Дундаж тэтгэврийн хэмжээ.

О.Номинчимэг: Эрдэнэбат гишүүн. Ажлын хэсгийн ахлагч хариулах уу? Эрдэнэбат гишүүний микрофоныг өгье.

Д.Эрдэнэбат: Би түрүүн бас тоонуудыг хэлсэн. Инфляцын түвшин буюу жигд мөнгөн дүн хувь гэдэг байдлаар холимог хэлбэрээр нэмээд явсан. Инфляцын түвшинд яаж нөлөөлөх юм гэх юм ахмадуудын тэтгэврийг сая, сая 500 болгочоод инфляцад яаж нөлөөлөх вэ гэдэг асуудлыг би Монголбанк илүү хариулсан нь зөв байх. Сангийн яам хоёр.

Гэхдээ Бат-Эрдэнэ гишүүний хэлдэг зөв. Улсын төсөв өөрөө ингээд даблдах байдлаар нэмэгдээд байхад бид нар бусад энэ тэтгэвэр, цалинтай холбоотой зүйлүүдээ 2 дахин яг нэмж чадаагүй. Өөрөөр хэлбэл, ихэнх ахмадууд маань маш бага тэтгэвэртэй учраас 5, 10 хувь, 20 хувь нэмсэн ч гэсэн маш багаар нэмэгдэж байгаа учраас энэ. Энэ бол Нийгмийн даатгалын сантай ч холбоотой асуудал байж байгаа.

О.Номинчимэг: Монголбанк энэ дээр нэмэлт хариулт өгөх үү? Хэн ирсэн байгаа билээ Монголбанкнаас? 2 номер микрофон.

М.Батболд: Гишүүний асуултад хариулъя. Монголбанкны хамгийн сүүлийн төсөөллөөр инфляц энэ оны эцэст болохоор 8.1 хувьтай, дараа оны эцэст болохоор 6.9, 27 оны эцэст болохоор 5.1 хувьтай байхаар суурь төсөөлөл гаргачихсан байгаад байгаа. Энэ дээр мэдээж тэтгэврийг хуульд заасны дагуу жилд 6 хувиар өсгөнө гэдэг нөхцөлийг суурь төсөөлөлд оруулсан байгаа.

Харин сая болон сая 500 мянган төгрөг хүргэж нэмэгдүүлэх хувилбартай. Төсөөллийг Монголбанкнаас л одоогоор яг тооцоолол хийдэг Монголбанкны нэгжээс төлөөлөл энд ирээгүй байгаад байна. Тэгэхээр яг нарийн тоо энэ дээр хэлэх боломжгүй байна. Хэрвээ та бүгд яг энэ хувилбараар ямар хэмжээ инфляц дээр нөлөөтэй байх вэ гэдэг нарийн тооцоолол хийлгэхийг хүсвэл яг тэр хувилбарынх нь дагуу бүх хувилбараар хийх боломжтой байгаа.

О.Номинчимэг: Бат-Эрдэнэ гишүүн 1 минут.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Та хэд маань энэ Өргөдлийн байнгын хороон дээр орж ирээд асуудал ярих гэж байж холбогдох албан тушаалтан ирээгүй гээд Монголбанк ийм хариуцлагагүй юм ярьж болохгүй. Танай Монголбанк чинь ер нь ажлаа хийж байгаа юм уу? Эсвэл Ерөнхийлөгч нь алга болчихно, эсвэл энэ холбогдох Байнгын хороон дээр асуудал шийдэх гээд бид нар асуудлаа оруулж ирж байхад ахмадууд гадаа гудамжинд 40, 50 хоног жагсаж цуглаад, суугаад байж байхад ийм асуудалтай байж болохгүй шүү дээ та нар. Та нар дандаа ахмадуудынхаа эсрэг үйл ажиллагаа явуулж байгаа шүү ний нуугүй хэдэхэд. Ядаж эс үйлдэхүй битгий гарга.

Сангийн яамнаас юм асуучихъя. Энэ тэтгэврийн доод хэмжээг 50 хувь нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээг 50 хувиар нэмэгдүүлснээр бүрэн тэтгэврийн доод хэмжээ сая 33500 төгрөг болж, 316.6 мянган хүн хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 858.6 мянган төгрөг болж 84.9 мянган хүн авах боломж нийт тэтгэвэр авагчийн 76.9 хувь нь тэтгэврийн доод хэмжээгээр буюу ижил түвшний тэтгэвэр авахаар байна. 1.6 их наяд төгрөг, 6 их наяд төгрөг нэмж шаардагдана. Улсын төсвийн ачаалал нэмэгдэнэ гэж байгаа юм. Энэ.../минут дуусав./

О.Номинчимэг: Сангийн яам 8 номер Ганбат Төрийн нарийн бичгийн дарга.

Ж.Ганбат: Гишүүний асуултад хариулъя. Засгийн газраас төсвийн төслийг боловсруулан ирэх оны төсвийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлчихсэн байгаа. Тэгээд төсөв энэ оны хувьд эхний 9 сарын байдлаар 1 их наяд гаруй тэрбум төгрөгөөр тасарч байгаа. Нөхцөл байдал бас гадаад орчны бас уул уурхайн гол бүтээгдэхүүний нүүрсний үнийн бууралттай холбогдуулан бас ийм амаргүй байна. Цаашдаа бас нөхцөл байдлыг бид бас ажиглаж байна. Тэгэхээр энэ оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр бас бид нарын тооцоо, саяын төсвийн тодотголоор бид орлогыг 3.3 их наядаар зардлыг 2 их наядаар бууруулаад байхад дахиад нөхцөл байдал бас ийм амаргүй байна. Тийм учраас бид яг үнэхээр яг шууд шулуухан хэлэхэд бодитоороо тэтгэврийн доод хэмжээ 1.5 сая болох боломжгүй.

О.Номинчимэг: 8 номер нэмж хариулъя.

Ж.Ганбат: Бид яах вэ энэ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр тооцоо хийгээд жишээ нь Засгийн газраас тэтгэврийг 6 хувиар нэмэгдүүлье гээд өргөн барьчихсан байгаа. Тэгээд 6 хувийг нь 8 хувь, 8 хувь болгоход 126 тэрбум

төгрөг. Ингээд 9.5, 10 хувь гээд ингээд нэмэгдүүлэхдээ дээшээ ингээд эх үүсвэрүүд нэмэгдээд нэмэгдээд явна. Засгийн газраас төсөв өргөн барьчихсан. Өчигдөр Төсвийн байнгын хорооны даргын хэлж байгаагаар урсгал зардал дээр Улсын Их Хурлын, одоо төсөв Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн барьчихсан. Улсын Их Хурлаас тодорхой чиглэлүүд хэлэх юм бол тэрний дагуу би тооцоо хийхэд бэлэн.

Гэхдээ саяын миний хэлдэг яг бодитоор нөхцөл байдал тийм амаргүй байгаа. Тэгэхдээ яах вэ Улсын Их Хурлаас өчигдөр Төсвийн байнгын хорооны даргын өгсөн чиглэлийн дагуу өнөөдөр 12 цагаас хамтарсан хамтарсан хурлын дараа Төсвийн байнгын хороон дээр Сангийн яамыг дуудсан байгаа. Тэгээд бид өгсөн чиглэлийн дагуу урсгал зардлыг 10 хувиар бууруулаад гаргах юм уу, 5 хувиар бууруулаад гарга гэж хэлэх юм уу яг өгсөн чиглэлийнх нь тоо, тооцооллуудыг нь хийнэ. Бодитоор тэгэхээр яг саяын таны хэлдгээр нэмэгдүүлэхэд.../минут дуусав./

О.Номинчимэг: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: Монголбанкнаас ямар хүн байгаа билээ? Монголбанкны хүн байна уу? Та нэрээ хэлээд албан тушаалаа хэлээд цалингийнхаа хэмжээг хэлж өгнө үү? Төрийн банкнаас нэрээ хэлээд албан тушаалаа хэлээд, цалингаа. Ахмадуудыг төлөөлж Алтанзул гуай өөр хэн байна? 689 мянган төгрөгийн тэтгэвэртэй буюу 572400 мянган төгрөгийн тэтгэврийг сардаа яаж зарцуулж байгааг энэ банкны төлөөллүүд хэлсний дараа хэлж өгнө үү. Төрийн банк, Монголбанк ирсэн хүмүүс цалингаа хэлээд, нэр, албан тушаалаа хэлээд араас нь ахмадуудаас төлөөлөл хэлж өгөөч тэгээд асуултаа асууя.

О.Номинчимэг: Мөнхбаясгалан гишүүн энэ албан тушаалтнуудын хувьд цалин ярина гэдэг бол хувь хүний мэдээлэл. Тэгэхээр бид нар бас манай Чуулган дэгийн хуулийн дагуу хуулийн, Монгол Улсын хуулийн дагуу явагдчихсан учраас энэ хүмүүс бол цалингаа хэлэх бол үүрэггүй тийм байгаа. Тэгэхээр энэ дээр бол хэрвээ юу гэвэл манай ахмадын төлөөлөл сая Мөнхбаясгалан гишүүний асуусан асуултад хариулах уу? 9 номер, 9 номерын микрофон. Алтанзул.

Ц.Алтанзул: Миний бие 572400 төгрөгийн тэтгэмж авдаг. Сая өнгөрсөн долоо хоногийн 3 дахь өдөр ахмадын тэтгэвэртээ гарах гээд материалаа өгчихсөн байгаа. Би яагаад ингээд банкны зээлд орчихсон бэ гэхээр Ар Жанчивлан рашаан сувилалд явах гээд. Тэгэхэд би тухайн үедээ 22 онд тэргэнцэртэй байсан. Тэргэнцэртэй намайг авч явахын тулд нөхөр маань авч явна. Нөхөр явахаар 2 зээ маань дагалдана. Ингээд 4 хүний эрхийн бичиг нааш цаашаа явах питёонк, очоод ундны ус авах гээд ингээд хэрэглээний мөнгө гээд ингээд 6 сарын зээл авчхаад зээлийн эргэлтэд явж байгаа. Тэгээд ямар азаар ганц охин төрүүлсэн юм. Охин маань ингээд амьдралыг маань ингэж болгож өөрөө хэдий машины зээлтэй ч гэсэн тэжээн тэтгээд ингээд үүргээ биелүүлээд ингээд явж байдаг юм. Тэгээд миний хувьд яах вэ тэгээд болж байна. Үр хүүхэд нь бас өөрсдөө бас ингээд өнгөрсөн 3 дахь өдөр намайг нэг залуу ална гэж заналхийлсэн шүү дээ. Би гэртээ хариагүй 6 хоног охиныдоо нуугдаж амьдарч байна. Өнөөдөр ахмадуудын нэрийн өмнөөс ингэж явчхаад ингээд заналхийлэлд өртөж байгаа нь ЧД-ийн цагдаад хандсан бүртгэлгүй дугаараас залгасан байна гэж байгаа юм. Тэгээд Мобикомоос асуухаар эзэнтэй байгаад байгаа байхгүй юу. Үнэхээр маш их ингээд энэ ахмадуудынхаа төлөө явахаар маш их троллууд дайрсан, маш их амь насанд минь хүртэл сүүлд нь ингээд заналхийлээд ингээд явж байгаа юм.

Тэгээд 572 мянга би яг энэ ташрамд бас хэлмээр байна л даа Үндэсний статистикийн газраас асууж байсан амьжиргааны доод түвшний 495 мянган төгрөг гэдэг энэ тоо яаж гарсан бэ гэхээр яг нарийвчилж детальчилж гараагүй байдаг юм байна лээ. Хүн өдөрт хэдэн кг калори юм иддэг юм, хэдэн кг хүнсний 8 хэрэглээний бүтээгдэхүүн иддэг юм энийг нь гаргаагүй хамгийн баян хүн, хамгийн ядуу хүн хоёрыг нь харьцуулаад олон улсын жишгээр гаргалаа гэж байгаа байхгүй юу. Өнөөдөр манайхан олон улсын жишиг ярихаа больё. Яг сайн жишгийг нь аваад өнөөдөр инфляц өслөө л гэж байна. Цаасан дээрх инфляцыг битгий хараад бай л даа та нар маань. Амьдрал дээр гараад байгаа тэр инфляцыг хараад үзээрэй. Үнэндээ инфляцыг хөөхөд хэзээ ч барихгүй. Монополын эсрэг газар эрх мэдлийг нь өгчихмөөр байна. Өнөөдөр манай Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайд маань ч гэсэн арилжааны банкнуудад тушаах эрх байхгүй зөвлөмж өгөөд сууж байгаа байхгүй юу өнөөдөр.

Тэгэхээр энэ эрх мэдэлжүүлэх газруудыг нь эрх мэдэлжүүлмээр байна. Бас яг энэ ташрамд хэлэхэд Ахмадуудын агентлаг гэдэг газрыг бий болгомоор байна. Өнөөдөр Сүхбаатар гуай ахмадын холбооны ерөнхийлөгч гэж байгаа боловч яг ахмадуудыгаа бас бүрэн гүйцэт төлөөлж чадахгүй. Би хүчин мөхөстөж байна. Тэгээд миний юу хязгаартай байна. Би бүүр Сүхбаатар гуай дээр очоод арилжааны 4 банк Монголбанкны Монголын банкныг, Монголбанкийг ярих юм биш шүү дээ. Аймаар худалч ерөөсөө далан худалч гээд нэр өгчихсөн байгаа. Ер нь Монголбанкны Ерөнхийлөгч Лхагвасүрэн болон Дэд ерөнхийлөгч Энхтайванг ажлаас нь халаад өгөөч гээд Их Хурлын дарга Амарбаясгаланд шаардлага бичээд өгчихсөн байгаа шүү дээ. Ерөөсөө амьдралаас тасарчихсан 5.1-ийн гэдэг нь энэ шал дэмий юм яриад бид нарыг ингээд төөрөгдүүлээд яваад байгаа байхгүй юу.

Тэгэхээр аргаа бараад Монголын банкны холбоонд нь хандаж үзлээ. Албан ёсоор хариу ирээгүй байна. Арилжааны банкнууд та нар жоохон хүн чанартай байгаад өгөөч. Хүн чанартай байгаад хэдэн муусайн ядарсан ахмадуудыг маань 1 удаадаа харж үзээд тэтгэврийн зээлийг нь 36 сараар олгоод өгөөч гэдгийг бүүр чин сэтгэлээсээ гуймаар байна. Дараа сард нь яах вэ ингээд тэтгэвэр нэмэгдтэл 26 он хүртэл 1, 1 сараар нь ингээд зээлийг нь олгоод өгчхөөч. Нэг их тийм гарзтай биш байх. Би бас.../минут дуусав./

О.Номинчимэг: Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: Ахмадуудын маань төлөөлөл инфляцыг яаж бууруулах дээр яриад хэрэггүй. Тэрийг төр хийх ёстой л доо. Засгийн газар инфляцаа барих ёстой байхгүй юу. Тэгэхээр би зүгээр л ингээд ийм л юм хүсээд байгаа шүү дээ. 572400 мянган төгрөгийн тэтгэвэртэй, 689 мянган төгрөгийн тэтгэвэртэй хүмүүс сард яаж амьдарч байгаагаа л энэ төрд сайхан яриад өг гэж л хүсээд байгаа юм. Яг юу авдаг юм, энэ амьдралд яг яаж хүрдэг юм гэдгийг л сонсмоор байх юм. Тэгээд сая манай Сангийн яам тэтгэвэр нэмэх боломжтой л гээд л хэлчихлээ л дээ. Тэгэхээр яг бодит амьдралыг сонсгоод өгөөч. Тэрнээс тэр инфляц тэр бол Засгийн газрын ажил шүү.

О.Номинчимэг: Асуусан асуултад хариулаад л байх шиг байна бид нарын хувьд. 9 номер 1 минут. Тодруулга хариулт 1 минут.

Ц.Алтанзул: Яг 572 мянгаар хэзээ ч 689 мянгаар амьдралд хүрэхгүй. Би бол 330 мянгаар, хүүхэд маань сонсголгүй учраас хөдөө орон нутгаас орж ирээд 7

жил болж байна. Подвал түрээсэлж амьдарч байна. Юуг нь нуух вэ дээ. Хүн юунд амьдарч байгаа нь сонин биш яаж амьдарч байгаа нь сонин учир. Тэгээд 330-ыг нь өгчихдөг юм. Манай нөхөр бас унаж татдаг хөгжлийн бэрхшээлтэй. Тэгээд нэгнийхээ юугаар ингээд орон сууцынхаа тэр түрээсээ төлөөд, хэрэглээгээ төлөөд нэгнийхээ юугаар эм тариагаа аваад нэг гэрт гурвын гурван хөгжлийн бэрхшээлтэй хүн байгаа байхгүй юу. Тэгээд хувцас авна гэсэн ойлголт байхгүй хүүхдээрээ л авхуулдаг юм. Ер нь яг ингээд халамж буухын өмнөхөн үед хөргөгч хоосордог, тэтгэврийн зээл авах хугацаа хүртэл бас хөргөгч хоосордог ийм л байгаад байгаа байхгүй юу. Хэзээ ч яг энэ 572400, 689 мянгаар огтоосоо хүрэхгүй. Би болохоор дэлгүүр явдаггүй. Манай гэр бүлийнхэн явж хүнсний юм авдаг байхгүй юу.

О.Номинчимэг: Жанчивын Галбадрах гишүүн асуулт асууя.

Ж.Галбадрах: Та бүхний энэ өдрийн амгаланг эрье. Надаа 2, 3-н асуулт байна. Ер нь манайхан хэр судалгаа хийсэн бэ гэдгийг Сангийн яам, Гэр бүл, Хөдөлмөр, нийгэм, халамжийн яамныхнаас бас асууя гэж бодож байна. Эхлээд Сангийн яамныхнаас эхлээд 6 хувь нэмнэ гэж төсөвт орж ирсэн. Энэ үед хэчнээн төгрөг нэмэгдэхээр байсан мөнгөн дүнгээр нь хэлбэл. Одоо тэгээд төсвийн бид нар чинь сая бас шийдэл гаргаад 8 хувь 2 функтээр нэмэгдүүлье гэсэн. Энэ үед хэчнээн төгрөгөөр нэмэгдэх вэ? Сая 500 болголоо гэдэг тооцоог хийсэн үү? Үүний мөнгөн дүнгүүдийг хэлээд өгөөч гэсэн. Тэгээд энэ үе маань ер нь багш, эмч нарын цалинг нэмэх гэдэгтэй ингээд яг давхардчихсан тэтгэвэр нэмэх гээд энэ асуудлууд маань яригдаж байна. Нийтдээ 1 830 тэрбум гэсэн тоо сонсоод байгаа. Тийм учраас энийг бас салгаад хэлээд өгвөл сайн байна.

Ер нь тэтгэврийн энэ шинэчлэлийн бодлогын талаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн халамжийн яамныхан ямар бодлого барих гэж байна вэ? Тэр бодлогынх нь талаас нь бас сонсодохъё. Өөрөөр хэлбэл тэтгэврээ энэ бодитой тогтоох тал дээр ер нь ямар байдаг юм? Сүүлийн 5 жилд нь хөдөлмөрийн доод, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин төлж байгаад тэтгэврээ өндөр тогтоолгочихдог ч гэдэг юм уу, зарим нь ийм боломж байдаг уу? Гэтэл насаараа ажиллаад ирсэн тэр цалингаараа ингээд тогтоолгож байдаг. Зарим овсгоотой нь гэдэг юм уу ийм байдлаар явдаг зүйл дээр ямар юу гэдэг юм хяналт гэдэг юм уу, энэ юмыг ер нь судалж үзээд ингэж тогтоолгож байгаа нь ер нь хэдэн хувьтай байдаг юм гэдэг ийм судалгаа байна уу? Түрүүн ажлын хэсгийнхэн дотроос 170-аад мянган хүн нь тэтгэврээ доогуур тогтоолгосон гэж байна.

Тэгээд тэр доогуур тогтоолгоно гэдэг нь ямар үндэслэлээр тэрийг доогуур тогтоолгосон гэж үзэж байгаа вэ гэдгийг бас асууя. Тэтгэвэр авагчдын дотор ер нь аль салбарынхан өндөр цалин, өндөр тэтгэвэр тогтоолгодог вэ? Хамгийн өндөр тэтгэвэр ер нь хэд байдаг юм Монгол Улсад гэдгийг асуучихъя. Мөн аль салбарынхан хамгийн бага тогтоох гээд байна? Хамгийн бага минимум тэтгэвэр хэд байна вэ өнөөдөр гэдгийг асуучихъя. Монголбанкныхнаас тэтгэврийн зээлийг их эрсдэлтэй зээл гэж үзсэн гэж байна. Тэгээд энэ ямар учир шалтгаантайгаар энэ эрсдэлтэй зээл гэж үздэг юм бэ? Хамгийн найдвартай зээл биш үү? Энэ ийм асуултуудыг асууя.

О.Номинчимэг: Өнөөдрийн манай Байнгын хорооны хуралдаанд Гэр бүл Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Аубакир сайд оролцож байна. Тэгэхээр Аубакир сайдын микрофоныг өгье. Тэтгэврийн бодлоготой холбоотой асуудал

Т.Аубакир: Та бүхэндээ энэ өглөөний мэндийг хүргэе. Ахмадуудаасаа уучлалт хүсье бас энэ бужигнаан дунд, энэ олон улс төрийн ээдрээтэй ийм үед ахмадуудыгаа бас хүйтэн, сэрүүнд гадаа суулгаад ингээд байж байгаагийн хувьд бас уучлалт хүсье. Удаа дараа бид нар бас уулзсан. Асуудлуудаа ний нуугүй ярилцацгаасан. 1.5 сая төгрөг болох боломж бол тун хэцүү. Сая Бат-Эрдэнэ гишүүн бас асуулаа 1.5 сая болгоход нийтдээ 4.1 их наяд төгрөг хэрэгтэй. 4.1 их наяд. Тэтгэврийг 6 хувь нэмэгдүүлэхэд 377.9 тэрбум төгрөг шаардлагатай 6 хувиар нэмэхэд. 8 хувь болгож нэмэхэд 504 тэрбум төгрөг шаардлагатай, хагас их наяд төгрөг шаардлагатай. Үүнийг бол бид нар бас Засгийн газрын түвшинд ярьсан. Өнөөдрөөс эхлээд ингээд Байнгын хороонууд Улсын Их Хурлын гишүүдтэйгээ яриад эхэлж байна. Ямар боломж бололцоонууд байна. Сая Сангийн яам хэлж байна төсөв тийм бас амаргүй байгаа. Өмнөх хэдэн жил, 10-аад жилийг бодоход Монгол Улсын төсөв хэдий том тэлсэн ч гэсэн.

Нөгөө талдаа бас бусад урсгал зардлууд дагаад нэмэгдэж байгаа хүн амын өсөлттэй холбоотой гэх зэрэг янз бүрийн шалтгаануудаа бид нар ярьж яриад эхэлсэн байгаа. Мэдээж хэрэг аливаа зүйлд гарц олдог. Гарц олохын төлөө Улсын Их Хурлын гишүүдтэйгээ хамтраад ажиллах ёстой.

Галбадрах гишүүн асуулаа. 6 хувиар нэмэхэд нийтдээ 378 орчим төгрөг, тэрбум төгрөг шаардлагатай байж байгаа. Энэ 6 хувь, 8 хувь гэдэг тоо ер нь яг хаанаас гарч ирсэн юм бэ, яагаад 8 хувь, яагаад 20 хувь биш юм бэ гэдэг асуултууд гарч ирнэ л дээ. Бид нар 2023 онд баталсан хуулийн хүрээнд итгэлцүүрээ Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр тэтгэврийг тооцдог илтгэлцүүрүүд байдаг. Энэ хүрээнд бид нар тухайн жилийн инфляцтай нь уялдуулж нэмэх хуультай. 2025 оны улсын төсвийн төсвийн хүрээний мэдэгдэлд манай Сангийн яамныхан сайн санана төсвийн хүрээний мэдэгдэлд инфляц 9.5 хувь байна гэж тооцож оруулж ирсэн. Гүйцэтгэл нь одоогоор 8 орчим хувьтай байж байгаа. Тийм учраас энэ инфляцынхаа гүйцэтгэлтэй нь уялдуулаад 8 хувь нэмэх нь зүйтэй юм гэсэн тооцооллууд гараад явж байгаа юм.

Галбадрах гишүүн сая бас асуулаа. Ер нь энэ улс төрчдийн попролттой холбоотой тооцоо, тооллогогүй сонгуулийн өмнө ахмадуудын тэтгэврийг нэмж шоуддаг. Ний нуугүй л хэлье маш олон хуулиуд орж ирдэг. Хууль хүчний байгууллагуудын сая Галбадрах гишүүн асуулаа 22 мянга орчим иргэн цэргийн тэтгэвэрт гарсан байдаг. НДШ төлөөгүй улсаас аваад ингээд нөгөө Нийгмийн даатгалын сангийн маань алдагдал гэх юм уу улсын төсвөөс шууд 1.4 их наяд төгрөгийн татаас. Энэ жилийн тэтгэврийн нэмэгдэлтэйгээ орж ирэхэд ингээд үндсэндээ 2 их наяд төгрөг гараад явчих шууд улсын татаас. Нөгөө талдаа орлогоороо буюу иргэн, аж ахуйн нэгжийн төсөв НДШ-ээр орлогоо бүрдүүлээд тэрийгээ баруун гараараа аваад зүүн гараараа ахмадууддаа тэтгэврээ өгдөг гэсэн эв санааны нэгдлийн үндсэн дээр явж байгаа ийм тогтолцоотой.

Нийгмийн даатгал дээр ямар реформууд та бүхэн бодоод явж байна вэ гэж асууж байна. Одоо яг манай яаман дээр үзэл баримтлалуудыг нь бусад яамнууд руу явуулчихсан байж байгаа. Хувийн тэтгэврийн сангийн тухай хууль явж байгаа. Бид нар яг энэ явж байгаа тогтолцооноосоо шууд ухрах уу үгүй юү гэдгээ бид нар сайн бодох хэрэгтэй. НҮБ-д бүртгэлтэй улсуудаас 160 гаруй улс нь яг манай Монгол Улстай адилхан тогтолцоогоор явж байгаа. Хуримтлал, Нийгмийн даатгалын сан. Сан маань өөрөө хуримтлалын сан байх ёстой гэж үзээд маш олон улсууд энэ хуримтлалын тогтолцоо руу шилжээд буцаад ухарч байна. Хуримтлалын тогтолцоотой байж байгаад энэ санхүүгийн зах зээлд хөрөнгө

оруулаад явах нь тогтвортой биш байна гэж. Энэ нөгөө зах зээл нь өөрөө тогтвортой биш болоод ирэхээр зэрэг ахмадуудын авдаг тэтгэвэр маань тогтвортой биш болоод эхэлнэ. Нөгөө хөрөнгө оруулалт нь ашиггүй болоод ирэхээр тэтгэвэр нь буурчихдаг, ашигтай болох үед өсдөг. Тийм учраас Польш гэдэг ч юм уу, Чили гэдэг улсууд маань энэнээс буцаад ухарч эхэлж байгаа юм. Тийм учраас манай дээр сонголттойгоор буюу энэ Нийгмийн даатгалын санд, мөн Хувийн тэтгэврийн сан.../минут дуусав./

О.Номинчимэг: Үлдсэн асуултад Рэнцэнханд 6 номер уу, Мөнхзул дарга уу? 6 номер Мөнхзул дарга. Дараа нь Сангийн яам, Монголбанкны хариултад бэлдээрэй.

Л.Мөнхзул: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Төрийн нарийн бичгийн дарга Мөнхзул гишүүний асуултад хариулъя. Тэтгэврийн шинэчлэлийг хийхдээ цаашдаа ер нь даатгуулагч ямар хэмжээний шимтгэл төлж байна тэр төлсөн шимтгэлтэйгээ уялдаатай тэтгэвэр л авах ийм бодлогын зорилт дэвшүүлж байгаа. Мөн түүнчлэн олон эх үүсвэрээр буюу суурь тэтгэвэртэй байх, төлсөн шимтгэлтэйгээ уялдаатай тэтгэвэр авах, дээрээс нь нэмэх нь хувийн тэтгэврийн даатгалын сангаас нэмэлт тэтгэвэр авах гэсэн ийм 3 тэтгэврийн эх үүсвэрээс тэтгэвэртэй байж ирээдүйн ахмад настан хангалттай хэмжээний орлоготой болно гэж тэтгэврийн шинэчлэлийн бодлогыг төсөөлж байна. Хамгийн өндөр тэтгэвэр авч байгаа даатгуулагчийн хувьд гэвэл 40 жил ажилласан даатгуулагч 5 сая төгрөгийн тэтгэвэр авч байгаа ийм кэйс байгаа. Жилд дунджаар өнөөдөр шинээр тэтгэвэр тогтоолгож байгаа тэтгэвэр авагчдын хувьд 5 жилийн цалинтай ба цалингүй ийм даат.../минут дуусав./

О.Номинчимэг: Галбадрах гишүүний асуулт нь хамгийн салбарын хувьд аль салбарынхан ерөнхийдөө дунджаар хамгийн өндөр тэтгэвэртэй байна, аль салбарынхан хамгийн бага тэтгэвэртэй байна гэсэн энд хариулаадхаач бас. 6 номер микрофон.

Л.Мөнхзул: Тэтгэврийн хэмжээ үндсэндээ 2 хүчин зүйлээс нөлөөлж тогтоогдож байна. Нэгдүгээрт дундаж цалингийн хэмжээ.

Хоёрдугаарт шимтгэл төлсөн хугацаа буюу ажилласан жил. Уул уурхайн салбарт ажиллагчдын хувьд дундаж цалин өндөр учраас тэтгэврийн хувь, хэмжээ илүү өндөр гарах магадлалтай байна. Хамгийн бага тэтгэвэр авдаг ажил мэргэжлийн салбараар авч үзвэл хөдөө аж ахуйн салбар буюу малчдын хувьд ихэвчлэн доод хэмжээгээр тэтгэвэр тогтоолгодог. Мөн 5 жилийн хугацаанд цалингүй, дараалсан цалингүй ийм даатгуулагчийн хувьд доод хэмжээний тэтгэвэр тогтоолгодог. Өндөр цалинтай салбарууд илүү өндөр тэтгэвэр авах магадлалтай. Цэргийн албан хаагчдын хувьд НДШ төлдөггүй. Мөн Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэрт нь зардал зарцуулдаггүй улсын төсвөөс 100 хувь хариуцаж явдаг. Энэ улсын төсвөөс цэргийн албан хаагчдын хувьд ажилласан хугацаа ихэвчлэн их байдаг учраас дундаж цалин хөлс бас харьцангуй.../минут дуусав./

О.Номинчимэг: Хариулах билүү? Одоо Сангийн яам хариулъя. 8 номер.

Ж.Ганбат: Бид Засгийн газраас тэтгэврийг 6 хувиар нэмэгдүүлэхэд нийтдээ 378 тэрбум төгрөгийг бид нар төсөвт тусгаж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байгаа.

О.Номинчимэг: Монголбанк түрүүний Галбадрах гишүүнээс 3 номерын микрофон.

Г.Борхүү: Галбадрах гишүүний асуултад хариулъя. Монголбанк Борхүү. Эрсдэлтэй зээл гэж үзсэн жоохон ташаа ойлголт байх. Ерөнхийдөө Монголбанк, банкнуудаас олгож байгаа зээлийн өсөлт дээр бол голчлон анхаардаг. Тэтгэврийн зээл бол яг та бүхэн мэдэж байгаа. Өмнө нь өр, орлогын харьцаа болон хугацааны хязгаартай байсныг 7 сард Монголбанкнаас цуцлаад ерөнхийдөө ямар нэгэн хязгаарлалтгүй олгосон байгаа. Яг энэнтэй холбоотойгоор ерөнхийдөө 6 сард байсан 1.6 их наяд орчим төгрөгийн тэтгэврийн зээлийн үлдэгдэл бол 500 тэрбумаар 1 сарын дотор бол огцом нэмэгдээд одоо 8 сарын 31-ний байдлаар 2.3 их наяд орчим төгрөгийн үлдэгдэлтэй болсон байгаа. Энэ нь юутай холбоотой вэ гэхлээр өр, орлогын харьцааг цуцалсан буюу сард олгож байгаа тэтгэврийн зээлдэгчдийн орлоготой тэнцэх хэмжээний 100 хувьд хүртэл хамгийн максимумаар нь олгох, тэгээд хугацааны бас яг банкнуудын өөрсдийн дотоодын бодлоготой холбоотойгоор нэмэгдэх юм.

О.Номинчимэг: Галбадрах гишүүн тодруулъя.

Ж.Галбадрах: Ажлын хэсгийн материал дээрээс харахад эрсдэлтэй зээл 150 хувийн гэж яриад байгаа. Тэгээд энэ ямар учиртай юм бэ? Энийг бүр тодорхой хэлээд өгөөч. Таныхаар эрсдэлгүй гэж тэр ташаа гэж ярьж байна. Тэрнээс гадна Сангийн яам сая 378 тэрбум гэсэн тэгээд 8 хувь 2 функтээр нэмэгдүүлэхэд 504 гээд сая Аубакир сайд хэлж байна. Тэгээд энэ эх үүсвэрийг бас тайлбарлаад байгаа шүү дээ. Бүх салбараас 10 хувийн юугаар гаргаж ирнэ гэсэн тэр нь тэр талыг бас баталгаажуулаад асуучихъя гэж бодож байна. Баярлалаа.

О.Номинчимэг: Сангийн яам 8 номер.

Ж.Ганбат: Засгийн газраас төсөв Улсын Их Хуралд өргөн барьчихсан. Одоо энд Улсын Их Хурлын дээр төсөв хэлэлцүүлэх явцад Төсвийн байнгын хорооноос болон Улсын Их Хурлаас өгсөн чиглэлийн дагуу бид тооцооллыг хийгээд өгөхөд бэлэн байгаа. Тэгээд өчигдөр Төсвийн байнгын хорооны дарга бол урсгал зардлыг 10 хувиар танах байдлаар багш, эмч нар, тэтгэврийн нэмэгдлийн эх үүсвэрийг гаргах бололцоотой юм уу гэдэг ийм байдлаар хэлсэн. Бид холбогдох тооцооллуудыг нь Сангийн яаман дээр яг урсгал зардлыг ямар байдлаар хийвэл тэр эх үүсвэрийг нь гаргах вэ гэдэг тооцоо дээр ажиллаж байгаа. Тэгээд энийг ингээд тооцоог нь гаргаад ирэх дээр Төсвийн байнгын хороо болон Улсын Их Хуралд, ажлын хэсэгт тэрний тооцоолоод танилцуулна.

О.Номинчимэг: Даваасамбуугийн Ганмаа гишүүн асуулт асууя.

Д.Ганмаа: Сайн байцгаана уу? Бас хэдэн тоо, хувь ажлын хэсэг бөгөөд энэ ирсэн хүмүүсээс асуугаадахъя. Өмнө нь ярьж байсан тэтгэвэр гэдэг чинь хамгийн эрсдэл багатай зээлтэйд тооцдог Америкаар нөгөө Кредит Скор гэдэг шиг тэр утгаараа хамгийн хувь багатай тэгээд хамгийн их эргэн төлөлт сайтай байдаг. Манай Монгол тэтгэвэрт гарсан хүмүүс маань хуучин социалист үеийн гэж ярьдаг шиг аягүй ер нь зээл авах маш дургүй. Бүүр болохгүй л зээл авдаг. Авсан бол маш хариуцлагатай төлдөг яг тэр үеийн төлөөллүүд байгаа юм. Энэ утгаараа хэдэн юм асуугаадахъя. Жишээлбэл, энэ тэтгэврийг хамгийн багаар тогтоосон тэтгэвэртэй хүмүүсийн нийт тэтгэвэрт байгаа хүмүүсийн хэдэн хувийг нь авдаг юм, дунджаар тогтоолгосон нь хэдэн хувь авдаг юм, хамгийн өндрөөр тогтоолгосон нь хэдэн хувь

авдаг юм, тэгээд дунджаасаа гадна голч гэдэг билүү нөгөө медиан гээд би асуугаад байдаг шүү дээ голч нь хэдийг авдаг юм? Би бас тэрийг мэдчихмээр байх юм. Яг энэ дээр тоотой хэлээд өгөөч.

Хоёрдугаарт, яг зээл авсан хувь нь нийт иргэд тэтгэврийн хүмүүсээс маань хэдэн хувь нь яг зээлтэй юм бэ? Хэдэн хувь нь огт зээлгүй амьдарч чаддаг вэ?

Гуравдугаарт, энэ амьжиргааны зардал гээд наад захын зардлууд байгаа шүү дээ байр, байшин, хоол унд, эм тарианы зардал. Эдгээр зардал нь Монгол Улсын хувьд хот хөдөөгөөрөө ямар ялгаатайгаар хэдэн төгрөгөөр яг тогтсон байдаг вэ энэ тооцоог хэлж өгөөч. Эрүүл мэндийн яамнаас хүн байгаа билүү энэ чинь? Энэ ажлын хэсгийн дүгнэлт дээр жишээлбэл энэ ЭМД-ын сангаас олгодог хэвтэн эмчлүүлэгч буюу архаг өвчтэй хүмүүсийнхийг тооны хувьд хязгаар тогтоосон гэж байна. Энэ хязгаарыг автоматаар шууд тогтоочихдог юм уу? Тодорхой өвчлөлийн шалтаг учир, дээрээс нь шалгуур үзүүлэлтээр тогтоож байгаа юу? Энэнээс болсон эрсдэл нь юу гэж харж байгаа вэ? Энэ дээр хариулт өгөөч.

О.Номинчимэг: Тэтгэврийн дундаж хэмжээ, бага хэмжээ, хувь, тэтгэвэр авагчдын хувь. 7 номер Батжаргал дарга.

Б.Батжаргал: Ганмаа гишүүний асуултад хариулъя. Нийгмийн даатгалын ерөнхий газар Батжаргал. Тэтгэврийн доод хэмжээ, одоо мөрдөж байгаа доод хэмжээ 572400 хувь тэнцүү тэтгэвэр дээр байгаа. 689 мянган төгрөг бүрэн тэтгэврийн доод хэмжээ байгаа. Энэ хэмжээгээр тэтгэвэр авдаг хүмүүсийн хувь нийт 515 мянган тэтгэвэр авагчийн 59.3 хувийг эзэлж байна. 689001 төгрөгөөс 1499999 төгрөг хүртэлх хэмжээний тэтгэвэр авч байгаа хүмүүсийн тоо 35.5 хувийг эзэлж байна. 1.5 саяас дээш тэтгэвэр авч байгаа хүмүүсийн тоо 5.2 хувийг тус тус эзэлж байгаа ийм статистик байна. Баярлалаа.

О.Номинчимэг: Нийт зээл авч байгаа тэтгэврээс тэтгэврийн зээл авч байгаа хүмүүс, тэтгэвэр авагчдын бас голч, медиан тэтгэвэр авч байгаа хүмүүсийн тоог хэн хариулах вэ? 7 номер.

Б.Батжаргал: Тэтгэврийн дундаж хэмжээ нийт тэтгэврийн төрлүүдийг дундажлаад үзэхэд 850 мянган төгрөг одоо байгаа. 850 мянган төгрөгийн тэтгэвэр авч байгаа хүмүүсийн хувь, хэмжээ дундажлаад үзэхээр 27 орчим хувийг эзэлж байна. Медиан тэтгэврийн хэмжээг одоогоор гаргаагүй байгаа. Бид нар бас гаргаад танилцуулъя. Баярлалаа.

О.Номинчимэг: Зээл авч байгаа хүмүүсийн тоон мэдээлэл хэн хариулах вэ? Наадах чинь ажиллахгүй дээ тийшээгээ. Хаан банк юм уу? Хаан банк түр 1 номерын микрофон дээр очоод хариулаач. 1 номерын микрофон өгье.

С.Энх-Ирээдүй: Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Намайг Энх-Ирээдүй гэдэг Хаан Банкнаас ярьж байна. Тэгээд надад бол нийт 312 мянган тэтгэвэр авагчийн судалгаан дээр хийсэн дата байгаа гэсэн үг. Саяын 512 гэж байх шиг байна гэхлээр их тооны онолыг төлөөлчихөөр хэмжээ юм байна. Хаан банкин дээр нийт 312 мянган тэтгэвэр авагч байгаагаас 60 хувь нь буюу 186 мянган тэтгэвэр авагч зээлтэй гэж байгаа. Тэгээд саяын 312 мянга дээр бид нарын байгаа судалгааны бракетыг харах юм бол түрүүний хэлсэн 189 мянгаас доош тэтгэвэр авагч нь нийт тэтгэвэр авагчийн 50 хувь дээр байдаг гэсэн үг. Тэгээд манай бракет нь 189-өөс 1 сая дээр 16 хувь байна. 1 саяас 2 саяын хооронд тэтгэвэр авдаг

хүний тоо 28 хувь дээр гээд. Тэгэхлээр 2 саяас дээш тэтгэвэр авдаг ийм тэтгэвэр авагчийн тоо нийт тэтгэвэр авдаг хүнийхээ 6 хувь дээр байгаа гэсэн үг. Тэгэхлээр түрүүний хэлснээр Батжаргал даргын хэлснээр мин биш.../минут дуусав./

О.Номинчимэг: Нийт Хаан Банкны мэдээллээр 60 хувь нь тэтгэврийн зээл авдаг байна гэж байна. Хот, хөдөөгийн энэ амьжиргааны үнийн ялгаа дээр судалгаа статистикийнхан байхгүй болохоор хариулах хүн байна уу? Эрүүл мэндийн яамнаас бас асуулт асуусан. Эрүүл мэндийн яамнаас хэн хариулах вэ? 1 номер дээр очъё. Өөрийнхөө нэрийг хэлээд Гамаа гишүүний асуултад хариулъя. 1 номерын микрофон.

М.Наранпүрэв: Сайн байцгаана уу? Энэ өдрийн мэндийг хүргэе. Эрүүл мэндийн яам Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Наранпүрэв байна. Тухайн ахмад настай иргэдэд зориулсан эрүүл мэндийн тусламжийн талаас нийт хөнгөлөлттэй эмийн 68 хувийг бол ахмад настнуудын эмийн хөнгөлөлт эзэлж байгаа. 24 оны байдлаар 91.8 тэрбум төгрөгийг зарцуулсан байгаа. Хөнгөлөлттэй эмийн үнийн дүнгээр сэтгэц, зан үйлийн эмгэг, эмэнд хамгийн их хөнгөлөлт олгосон байдаг. Мөн даралт ихсэлт болон бусад эмүүдийг бол энэ хөнгөлөлттэй эмэнд байгаа. Нийт 2024 оны байдлаар ЭМД-ын хамрагдалтад дунджаар 93.4 хувь буюу нийт даатгуулагчийн 68.6 хувийг төр шимтгэлийг нь хариуцах иргэд байгаа. 22-24 он хүртэл ахмад настны тусламжийн лавлагаа шатлал болоод эмийн хөнгөлөлт, анхан шатын тусламж үйлчилгээнд зэрэг бүх тусламжууд дээр мөнгөн дүнгээр дүнгээр болон.../минут дуусав./

О.Номинчимэг: 1 номер нэмж хариулъя.

М.Наранпүрэв: Иргэдийн тоо бол нэмэгдээд нийтдээ, нийт дүнгээр нэмэгдсэн дүнтэй байгаа. Хамгийн сүүлийн асуултад хариулахад архаг өвчний квот тавьдаг гэдэг асуудал нь бол үндсэндээ хойшлуулах боломжтой, эмээр эмчлэх боломжтой зөвхөн оношны тохиолдлууд дээр квот дээр байгаа. Өөрөөр хэлбэл хяналтад явах боломжтой тохиолдлуудыг бол мөнгөн дүнгээр тухайн эмнэлгийн нийт төсвөөс хасагдсан зардлаар хасагдаж байгаа. Зайлшгүй үзүүлэх тусламж болоод архаг өвчний хүндрэлүүд нь бол эмнэлгүүд дээр квот тавигдахгүй тусламж, үйлчилгээ үргэлжилж байгаа.

О.Номинчимэг: Ганмаа гишүүн тодруулъя.

Д.Ганмаа: 2 юман дээрээ тодруулъя. Энэ амьжиргааны зардлыг би асуугаад байгаа заавал хот, хөдөө байх хэрэггүй. Зүгээр Монгол Улсын хувьд амьжиргааны зардал наад захын хэлсэн шүү дээ байр байшин, хоол унд, эм тариа энэний зардлын ийм тоо, статистик байдаг байлгүй дээ. Тэрийг авчихъя тэгэх үү энэ тэтгэвэртэй, зээлтэй холбоотой асуугаад байна шүү дээ. Хоёрдугаарт энэ Эрүүл мэндийн яамны хариултыг би сайн, бүтэн ойлгосонгүй. Би асуулт нь ийм байсан шүү дээ. Архаг өвчний тооны хязгаарыг тавьж байна гэж ажлын хэсэг дээр ороод ирлээ шүү дээ. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ дээр. Тэгэхлээр би хэлсэн шүү дээ. Ямар шалгуур үзүүлэлтээр, ямар байдлаар энийг авч байгаа юм бэ нэгдүгээрт? Энэний хор уршгийг нь яаж харж байгаа вэ?

О.Номинчимэг: Амьжиргааны зардлаар 5 номерын микрофон өгье.

В.Рэнцэнханд: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Рэнцэнханд байна. Үндэсний статистикийн хорооноос бол жил болгон

амьжиргааны доод түвшнийг бүсээр баталдаг байгаа. Тэгээд 25 оны 1 дүгээр сард баталсан үнэлгээгээр бол Баруун бүс 490 мянга, Хангайн бүс 488900, Төвийн бүс 483 мянга, Зүүн бүс 482900, харин Улаанбаатар хот бол 495400 төгрөгийн амьжиргааны доод түвшинтэй байна. Энэ бол нөгөө тэтгэврийн доод хэмжээнээс хамаагүй доогуур үзүүлэлттэй байгаа.

О.Номинчимэг: Эрүүл мэндийн яам 1 номерын микрофон.

М.Наранпүрэв: ...-тийн тухайд болохоор архаг өвчин маань өөрөө тасралтгүйгээр эмчлүүлэх шаардлагатай бөгөөд 1 удаагийн эрүүл мэндийн тусламжаар эмчлэгдэхдээ цочмоогоор хүндэрсэн, эсвэл зайлшгүй шаардлагатай тохиолдлууд эмчлэгдэж байгаа. Тэр нь бол энэ шалгуурт орохгүй байгаа. Шалгуур дээр архаг өвчин маань тасралтгүй гэрээрээ өдөр тутамдаа эмээ уух буюу хянагдах тохиолдлын оношны бүлгээрээ архаг өвчинд тооцогдож байгаа гэсэн үг.

О.Номинчимэг: Ганмаа гишүүн тодруулъя.

Д.Ганмаа: Ахиад л энэ 2 дээрээ энэ амьжиргааны зардлын ингээд тоо 490, 492 мянга энэ тэр гэхээсээ илүүтэйгээр би ийм амьдралд хэрэгтэй тоо асуугаад байгаа байхгүй юу. Зүгээр мөнгөн дүн гэхээсээ илүүтэй энэ амьжиргаанд энэ хүрэх үү? Байр байшин, хоол унд, эм тариа. Ингээд наад захын амьжиргааны зардал гэж юм байдаг шүү дээ. Эцсийн эцэст манай энэ тэтгэврийг сая энэ гадаа сууж байсан хүмүүст төлөөллүүд эд нарын ярьж байгаа гол асуудал нь эндээ байгаад байгаа байхгүй юу. Тоондоо биш хүнээ бодоод энэ дээр яг амьдралтай тоон дээр энэ чинь яг амьжиргаандаа жишээлбэл хоолонд тэдэн хувь зарцуулагддаг, байрандаа тэдэн хувь, эм, эмчилгээндээ тэдэн хувь нь зарцуулагдаад энэ хүн энэ мөнгөөрөө ингэж амьдрах боломжтой байна гэсэн тийм маш яг ийм форматаар хариулт авчихмаар байна.

Архаг өвчин дээр яг адилхан. Эрүүл мэнд гэдэг чинь эрүүл мэндийн энэ архаг өвчлөлийг ярьж байхдаа хүнээ яримаар байгаа байхгүй юу. Энэ хүмүүс ч энэ архаг.../минут дуусав./

О.Номинчимэг: Хэн хариулах вэ? 6 номерын микрофон Мөнхзул дарга.

Л.Мөнхзул: Амьжиргааны доод түвшнийг тогтоох энэ судалгааг Үндэсний статистикийн хорооноос гаргадаг. Тэгэхээр манайх шууд гаргадаггүй. Тэгэхдээ энэ яагаад 495 мянган төгрөг байгаа юм бэ гэхээр Улаанбаатар хотод амьдарч байгаа 1 хүн орон сууцад наад захын энгийн дулаан байх хэрэгцээгээ хангаад, эм тариагаа хэрэглээд, мөн түүнчлэн бүх хэрэглээгээ хангахад наад зах нь 495 мянган төгрөг шаардлагатай гэсэн үг. Тэгэхээр 5 ам бүлтэй хүний хувьд, өрхийн хувьд 495-ыг 5-аар үржүүлээд өөрөөр хэлбэл наад зах нь 2 сая 400 орчим мянган төгрөгийн мөнгө нь орлоготой дүйцэхүйц хэмжээний орлоготой байж тэр ам бүл өрхийн хувьд дулаан байх, эрүүл мэндийн үйлчилгээ авах, боловсрол эзэмших бүх хэрэгцээ нь хангагдана гэсэн ийм ерөнхий судалгааны дүн гэж үзэж болно.

Тэгэхээр энэ өрхийн амьжиргааны түвшин энэ 2025 оны 1 дүгээр сард гарсан Үндэсний.../минут дуусав./

О.Номинчимэг: 1 номер Эрүүл мэндийн яам нэмэлт хариулт өгье.

М.Наранпүрэв: Түрүүний ахиад мөн адилхан ярья. Тухайлах юм бол чихрийн шижинтэй эмчлүүлэгч байлаа гэж бодоход тасралтгүй эмчилгээгээ амбулаторийн түвшиндээ хянуулаад, анхан шатны эрүүл мэндийн байгууллагадаа хянуулж байх явцдаа хэрвээ цочмогоор өвдөх юм бол эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг даатгалаараа шууд авах боломжтой. Тэр архаг гэдэг нь тухайлах юм артерийн даралт ихсэх, чихрийн шижин гэх мэтчилэн тодорхой архаг өвчнүүд байгаа. Тэдгээр өвчнүүд нь хэвтэн эмчлүүлэхдээ бол хэрвээ цочмогоор өвдвөл оношлуулах эмчлүүлэх боломжтой. Харин зүгээр зөвхөн ямар нэгэн хүндрэлгүй байгаа үедээ хяналттайгаа, хяналтынхаа түвшиндээ бол эмчлүүлж болно гэсэн ийм зарчмаар эмчлэгдэж байгаа.

О.Номинчимэг: Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн асуулт асууя.

Ц.Мөнхтуяа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Гадаа ахмадууд нь зогсчихсон, эмч багш нар нь жагсчихсан, ажил хаячихсан маш хүнд байна. Өнөөдөр л энэ асуудал гэнэт гараад ирчихсэн юм биш шүү дээ. Сүүлийн 30 жил ингэж явна шүү дээ. Тэгээд энийг яагаад засахгүй байгаа юм? Одоо тэгээд өнөөдөр энд Төсвийн байнгын хорооны дарга нь сууж баймаар байна. Сангийн сайд нь сууж баймаар байна. Дандаа ингээд чиглэлийн дагуу ажилладаг гүйцэтгэх ажилтнууд суулгаад энд загнаад суумааргүй байна бид нар. Яг шийдвэр гаргагчид нь өнөөдөр энд бодитой сууж баймаар байна. Тэгээд одоо тэтгэвэр нь нэмэх боломж байгаа юм уу, байхгүй юм уу? Ямар ч шийдвэр байхгүй. Тэгээд 689-хөн, 689 мянган төгрөгөөр яаж амьдрах юм, яаж амьдарч байна гэж асуухаасаа ч ичих хэрэгтэй. Яаж амьдарч байгаа нь ойлгомжтой л байна шүү дээ. 572 мянган төгрөгөөр яаж амьдрах юм. Ийм байж байж тэгээд л тулга тойрсон өнөө маргааш аргацаасан хурал хийсэн дүр эсгэж ингэж суудгаа болимоор байна. Яг зүгээр бодит байдалтайгаа нүүр тулаад үнэнтэйгээ л нүүр тулъя хэдүүлээ. Шийдсэн юм юу ч байхгүй байна шүү дээ. Бид нар ингээд гишүүн болоод 1 жил өнгөрч байна. Юу шийдэв ээ? Юу ч шийдээгүй.

Тэгээд шийдвэр гаргах түвшинд байгаа хүний хувьд хууль санаа ажиллаад л зарчмын зөрүүтэй санал хүртэл аргаа ядаад л оруулаад л ирэнгүүт нөгөө Төсвийн байнгын хороо, Сангийн сайд нь болохгүй гээд л дандаа хэлдэг. Болохгүй юм бол тэгээд энд бид нар байх хэрэг ер нь юу байгаа юм? Ахмадууд чинь өлбөрч үхлээ. Тэтгэврийг нь нэмээч ээ. Лувсанжамц гишүүн хэлсэн шүү дээ. Өдөр бүр ард иргэд чинь тэвчиж амьдарч байгаа шүү гэж. Үнэн шүү дээ. Тэгээд өөрсдөө болохоор ингээд зам гүүр, барилга байшин, тендер төсөл юу байна цавчиж танаж, дээрэмдэж, хулгайлж ард иргэдээ болохоор ингээд гуйлгачин шиг өлбөрүүлээд ингээд л амьдруулж байгаа нь үнэн шүү дээ. 600 мянгаар хүн яаж амьдрах юм айн? Ийм байдалтай ийм ичгэвтэр байдалтай тэгээд шийдсэн юм юу ч байхгүй. Өдөр болгон хурал. Нөгөө ажил муутай хурал хийх гэдэг шиг. Байнгын хурал. Энэ хурлаас чинь юу шийдэгдээд байгаа юм бэ? Үнэхээр утгагүй байна.

Тэгээд 490 тэрбум төгрөг зарчмын зөрүүтэй санал оруулаад ирэнгүүт наадах чинь Мөнхтуяа хууль зөрчиж байна гээд ингээд хуулиар далайлгаад тэр хуулиудыг чинь өөрчилж болдоггүй юм уу? Хуулиараа битгий боомилоод байгаач. Монгол үйлдвэрчний эвлэлийн холбоо, Засгийн газар гээд, Ажил олгогч эздийн холбоо гээд ард иргэдээ гурван талт хэлэлцээр гуйлгачин болгодог энэ даваан балиар ийм тогтолцоогоо боль. Үйлдвэрчний эвлэлийн байгууллага сайн ажиллаж байсан бол өнөөдөр ахмадууд чинь ингээд гуйлгачлаад энд суухгүй. Үйлдвэрчний эвлэл үнэхээр муу ажиллаж байгаа. Засгийн газрынхаа кармад орчихсон. Тэгээд

өнөөдөр гэнэт амьдрал ийм болчихсон юм шиг битгий ярь. Одоо бодитой юмаа л ярь бүгд.

О.Номинчимэг: Ойлголоо. Ер нь санал байгаа Мөнхтуяа гишүүнээ. Гэхдээ одоо бид нар бид нар цөмөөрөө хамтдаа шийдэхийн төлөө л энд сууж байгаа. Санал, дүгнэлт гаргаад Эрдэнэбат гишүүн бас тодорхой хэмжээнд ажиллаад энэ санал, дүгнэлтийг дахиад Төсвийн байнгын хороо, Нийгмийн бодлогын байнгын хороон дээрээ танилцуулаад ажлын хэсэг Төсвийн байнгын хорооны дарга энэ дээр бас ажиллах гэж байгаа. Тэгээд энэ дээр бас юм хэлмээр байгаа нь энэ тэтгэврийн асуудал ийм болоод энэ хүндрэлтэй байдал бол улс төрчдийн өөрсдийнх нь буруу байхгүй юу. Тэрийгээ бид нар хүлээн зөвшөөрөх ёстой. Энэ төрийн албан хаагчид гэхээсээ илүү улс төрчид өөрсдөө поп шийдвэр гаргаж тогтолцоогоо эвдсээр байгаад өдий зэрэгтэй болсон. Тэгэхээр буруугаа өөрсдөөсөө бид нар бас хайж тэрийгээ засах чиглэлүүд явах ёстой гэж харж байгаа.

Би Байнгын хорооны дарга гишүүний хувьд бас юм тодруулчихмаар байна. Асуулт байна. Түрүүн Аубакир сайд хариултдаа хэлж байсан жил болгон 2 их наяд орчим төгрөг татаас хэлбэрээр зарим мэргэжлийн хүмүүсийн тэтгэвэрт явдаг. Тэтгэвэр даатгалын НДШ төлдөггүй боловч шууд 2 их наяд бол татаас хэлбэрээр гардаг гэдэг тоо хэлж байсан. Тэгэхээр энэ дээр Нийгмийн даатгалын сангийнхан юм уу энэ яамныхан яг ямар ямар мэргэжлийн албан тушаалтнуудын, эсвэл салбарын хүмүүс энэ татаасыг эдэлдэг юм бэ, НДШ төлөхгүй мөртөө шууд төсвөөс татаастайгаар нийгмийн даатгалаа төлүүлдэг юм бэ гэдгийг яг энэ байгууллага байгууллагаар нь хэлээд өгөөч.

Хэдэн номер вэ? 6 номерын микрофон.

Л.Мөнхзул: Гишүүний асуултад хариулъя. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Мөнхзул. 2024 оны гүйцэтгэлээр төрөөс тэтгэврийн санд олгосон татаасны хэмжээ нь 1.1 их наяд төгрөг байсан. 25 оны төсвөөр 1.4 их наяд 52 сая төгрөг байгаа. 452 сая төгрөг байгаа. 452 тэрбум төгрөг байгаа. Төрөөс тэтгэврийг нь хариуцах иргэдийн улсын төсвийн санхүүжилт төсвөөр 791 тэрбум. Энэ дотор хэн ордог вэ гэхээр 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэвэрт 338 тэрбум төгрөг. Цэргийн албан хаагчдын тэтгэвэрт олох зардал 404 тэрбум төгрөг. Зарим иргэний тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай хуулийн дагуу олгож байгаа татаасны хэмжээ 17 тэрбум төгрөг, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин даатгалын сангийн 95 оноос өмнөх тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэвэрт 5 тэрбум төгрөг, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу өндөр насны тэтгэврийн тусгай зохицуулалтын дагуу олгох тэтгэврийн хэмжээ 26 тэрбум төгрөг.

Ингээд тэтгэвэр нэмэх арга хэмжээг Нийгмийн даатгалын сан буюу Тэтгэврийн даатгалын сан орлогоороо хэрэгжүүлж чадахгүй байгаа учраас тэтгэврийн хэмжээг инфляцын түвшиндээ нэмэгдүүлэхэд шаардагдах хөрөнгийг мөн улсын төсвөөс 300 тэрбум төгрөг олгож байгаа. Үүн дээр нэмээд нийгмийн даатгалын буюу тэтгэврийн даатгалын шимтгэлээр орж ирж байгаа орлого маань нийт зарлагаа нөхөж чадахгүй байгаатай холбогдуулан 360 тэрбум төгрөгийн алдагдлыг мөн улсын төсвөөс олгож байна. Ингээд нийлбэр дүнгээрээ 1.4 их наяд төгрөгийг 2025 оны төсөвт тусган Нийгмийн даатгалын санд сар бүр шилжүүлэн олгож байна.

О.Номинчимэг: Яах вэ алдагдал ... юм байна. Та сая хэллээ шүү дээ цэрэг бол цэргийн арми эд нар гэж ойлголоо. Эсвэл энэ нь цэргээс гадна өөр түрүүн хууль хүчний байгууллагынхан гээд сайд үгэндээ дурдчихсан. Өөр албан тушаалтан салбарынхан байна уу? Цэргээс өөр, армиас өөр. Дээр нь тэр 9 дүгээр зүйлийн дагуу, тусгай зохицуулалтын дагуу гэж байна. Энд чинь юу юу анх хамаардаг юм бэ тэрийг тодруулаад өгөөч. 6 номер, 7 номер. 7 номерын микрофон өгье.

Б.Батжаргал: Гишүүний асуултад хариулъя. Нийгмийн даатгалын ерөнхий газар Батжаргал. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд зааснаар цэргийн 10 байгууллага цэргийн тэтгэвэр гэсэн ангилалд, категорид хамаарагддаг. Үүнд зэвсэгт хүчин, арми, хилийн цэрэг, дотоодын цэрэг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шүүх шинжилгээний газар, АТГ, Онцгой байдал, Гамшиг гэсэн ийм байгууллагууд нийт 10 байгууллагууд энэ Цэргийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль буюу шимтгэл төлдөггүй. Тэгээд тэр тэтгэвэрт гарахдаа улсын төсвөөс санхүүждэг ийм харилцаанд хамаарагдаж хуулийн хэрэгжилтийг бид нар зөвхөн тэтгэврийг нь тогтоож олгох үйлчилгээг нь хийж ажиллаж байна.

9 дүгээр зүйлийн тусгай зохицуулалт гэдэг харилцаа юу вэ гэхээр 2024 онд батлагдсан Нийгмийн даатгалын багц хуульд зааснаар 2 өндөр насны тэтгэвэр авагчийн аль нь бурхан болсон тохиолдолд ар гэрт үлдсэн 1 гэр бүлийн гишүүнд нь авч байсан тэтгэврийн 20 хувийг нь олгодог ийм зохицуулалт үйлчилж байгаа. Тэгээд 1995 оноос өмнө тэтгэвэрт гарсан хүмүүсийн хувьд аль нэг нь бурхан болсон тохиолдолд өгч байгаа зардлыг нь улсын төсвөөс өгч байгааг энэ 9 дүгээр зүйл буюу тусгай зохицуулалт гэж нэрлэж байгаа юм. Баярлалаа.

О.Номинчимэг: Баярлалаа. Хариултаа авчихлаа. Ер нь зэвсэгт хүчин армийг ойлгоод байгаа. Тэгээд тэрэнтэй зэрэгцээд жишээ нь иргэдэд үйлчилж байх ёстой Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийнхэн ч байдаг юм уу, Шүүх шинжилгээнийхэн ч байдаг юм уу эд нар маань бас ингээд тэтгэврээ юу яадаг юм байна шүү дээ татаасаар авдаг юм байна шүү дээ. Тэрний логик ер нь асуудлууд нь яагаад ингэсэн юм гэдгийг бас харах л ёстой юм байна. Тэгээд алдагдалтай алдагдалтай гэххээд яг энэ чинь шударга систем болж чадаж байна уу гэдгийг бүгдийг нь ингэж тал талаас нь харахгүй бол ер нь зоригтой энэ дээрээ нийгмийн даатгалын тогтолцоо дээрээ шинэтгэл хийхгүй бол угаасаа хэцүү болж байгаа гэдгийг бүгдээрээ л хаа хаанаа ойлгож байгаа учраас хаа хаанаа л их анхааралтай ажиллах хэрэгтэй байна гэж харж байна.

Ингээд асуулт асууж дууслаа гишүүд.

Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгье.

Энэ бас тийм дараагийн хурал 2 хамтарсан Байнгын хороогоор орж ажлын хэсэгт бас энэ санал, дүгнэлтүүд очих ёстой.

Пунсалмаа гишүүнээр тасалъя. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн үг хэлье.

Б.Бат-Эрдэнэ: Зарим гишүүд маань өөрсдөө хууль тогтоох засаглалд байж байж, хуулиа өөрчлөх бүрэн эрх нь байж байж бусад руу буруугаа чихээд гараад явж байх жишээтэй л байна. Бид нар нэг зүйлийг их сайн бодох хэрэгтэй байна л даа. Хууль дээр асуудал байгаад байгаа байхгүй юу. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам энийгээ ерөөсөө хөндөж ярихгүй байна та нар. Хуульд чинь

тодорхой салбар, чиглэлүүдээр цалингийн хэмжээ, нэмэгдлүүдийг ялгамжтай байдлаар тогтоох асуудал чинь эх сурвалж тэнд яваад байгаа шүү дээ. Энэ чинь нэгдсэн бодлого байхгүй байна гэж миний хэлээд байгаа энэ байхгүй юу. Энийгээ нэгдүгээрт янзлах хэрэгтэй.

Тэгэхгүй бол өнөөдөр бид нар ингээд муудалцаад юм шиг ингээд сууж байгаа асуудал 10 жилийн дараа бид нар ингээд л сууж байна. Манай байгаль орчны салбарынхан тухайлбал манай байгаль орчны салбарынхны цалин мөнгө хуульд тодорхойлон тусгагдаж чадахгүй байгаад байгаа учраас нэмэгдлүүд тодорхойлон нэмэгдэж тусгагдаж чадахгүй байгаад байгаа учраас энийг та хуульд оруулж өгөөч гэж лоббиддог байхгүй юу. Тэгээд энэ үнэн шүү дээ. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам энэ дээрээ нэгдсэн бодлогоо гаргаж ажиллах хэрэгтэй гэж би харж байгаа юм.

Хоёрдугаарт ажлын хэсэг ажилласанд баярлалаа. Тэгэхдээ энэ дээр нэг зүйл дутуу байна ажлын хэсгийнхэн. Ямар хуулиас улбаатайгаар ийм асуудал үүсчхээд байгаа юм бэ гэдэг дүгнэлт дотроо хууль, эрх зүйн үндэс, заалтуудыг та хэд маань оруулж өгөхгүй бол зүгээр тооцоолол хийсэн хийсвэр ажил болчихоод байгаа байхгүй юу. Сангийн яамнаас, Эдийн засгийн хөгжлийн яамнаас, Монголбанкнаас, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас авсан ярьж байгаа хэлбэр дээр нь дүгнэлтээ бичээд оруулж ирээд байхаар наадах чинь олигтой ахиц гарахгүй гэдгийг хэлчихье. Тэгээд энийг хэдүүлээ ахиад засаж сайжруулаад явах ёстой гэдэг ийм зарчим дээр байна.

Гуравдугаарт, Өргөдлийн байнгын хороо бид нар чадавхжих хэрэгтэй байна. Одоо бид нар энд ямар ч шийдвэр гарсан Төсвийн байнгын хороон дээр магадгүй очоод л унадаг. Тэгэхээр бид нар энд яг суусны хэрэг байгаа юу, үгүй юу гэдэг асуудал хөндөгдөж байгаа юм. Тэгэхээр энэ дээр шаардлагатай тохиолдолд Өргөдлийн байнгын хороон дээр энэ орж ирсэн асуудалтай холбоотойгоор хууль, эрх зүйн хувьд магадгүй Байнгын хороон дээрээ бид нар дэд ажлын хэсэг байдаг юм уу гаргаад эрх зүйн өөрчлөлтийг хийх асуудлуудыг бид нар энэ дотроо ярьж эцэслэж явмаар байна.

Тэгэхгүй бол орж ирсэн өргөдлийг хэлэлцсэн болоод дөрвөлжин ширээ тойрч суугаад хайран цагаа бараад дараа нь бид нар дэмжсэн шүү дээ. Төсвийн байнгын хороо дэмжээгүй шүү дээ, мэргэжлийн Байнгын хороо дэмжээгүй шүү дээ гээд амыг нь хаагаад ажил оромдсон хэлбэр дээр яваад баймааргүй байна. Энийг би бас бид нар манлайлан авч хийх ёстой болов уу гэж харж байгаа юм.

Дөрөвдүгээрт би төрийн байгууллагууддаа шүүмжлэлтэй хандаж байгаа. Би өөрөө төрийн байгууллагаар бас олон жил явсан хүн. Нөгөө гөлөг төөрүүлж байгаа юм шиг л хариулсаар л та бүхэн он цагийг үзсээр л байна. Ахмадуудын чинь амьдрал муудсаар л байна. Яг ний нуугүй хэлэхэд бид нар ажил хийж байгаа хүнийг тэтгэвэрт гарахад нь шууд ядуурлын доод түвшин рүү оруулж байгаа шүү дээ. Энэ үнэн шүү дээ. Яаж наад тэтгэврээр чинь хүн амьдрах юм бэ? Анхдагч хэрэгцээгээ хангаж чадахгүй түвшинд байна шүү дээ. Идэх уух юм авч чадахгүй байна, дулаан байж чадахгүй байна. Тэр байр савны өр, зээл бүр дүүрсэн. Яаж ийж байгаад өвчиндөө хэдэн төгрөг зэрэг зарцуулчих л боломжийг л хангаж байгаа юм.

Тэгээд бид нар энэ анхдагч хэрэгцээг нь ядаж хангах түвшин дээр төр иргэдийнхээ төлөө ажиллах дээр төрийн байгууллагууд ажиллаад өгөөч ээ,

шийдэлтэй байгаач ээ, битгий өөрсдийнхөө бодлогыг хамгаалагчийн байр суурин дээр байгаад байгаач. Гарц, шийдэл рүүгээ ажиллаач гэдгийг уриалмаар байгаа юм. Тэгээд энэ дээр бол ажлын хэсэг байгуулаад эцэслэтэл нь хэдүүлээ л явах ёстой гэдэг ийм саналыг ажлын хэсэг, Байнгын хороон даргадаа бас уламжилж байна. Тэгээд бид нар нэг тал шүү. Бид нар нэг тал.

О.Номинчимэг: Энэ асуудлыг угаасаа олон ч ахмадууд маань тавьж байгаа. Өргөдлийн байнгын хороонд чинь өргөдөл ирсэн учраас бид бас төсөв хэлэлцэж байгаа энэ үед заавал шийдэх ёстой гээд богино хугацаанд ч гэсэн бас Эрдэнэбат гишүүн маань ажиллаад энийгээ Төсвийн байнгын хороо, Хүний хөгжлийн байнгын хороогоор заавал хэлэлцүүлэх дэг байхгүй. Гэхдээ заавал хэлэлцүүлээд энэ дээр арга хэмжээ авъя гээд ингээд бас явж байгаа болохоор тодорхой хэмжээний үр дүн гарна гэж итгэж байгаа. Улсын Их Хурлын гишүүд ч гэсэн үүнийг бас дэмжиж ажиллаж байгаа гэж бодож байна.

Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: Ажлын хэсгийн ахлагчийн хувьд хэлэхэд энэ тэтгэврийн асуудлыг бид нар нэлээн нухацтай ярихгүй бол нэгдсэн чуулган дээр манай олонх гишүүд зарчмын байр суурь өөр өөр байсан шүү дээ. Бүх ахмадын тэтгэврээр яг шударгаар тогтоочихсон л гэж ойлгоод байгаа байхгүй юу. Тэгэхээр өнөөдөр нэлээн эргэлзээ гарч байна. Янз бүр байна. 170 мянган хүн зөрүүг нь арилгах хэрэгтэй байна. Энэ нэгдүгээрт хийсэн том дүгнэлт шүү. Тэгэхээр санал хураах дээр энэ нэлээн чухал нөлөөтэй.

Тэтгэврийн Нийгмийн даатгалын хууль дээр инфляцын түвшин дундаж түвшнээс дээш нэмэгдүүлнэ гэдэг ойлголт нь хуульд нийцүүлж нэмэх ёстой гэдэг энэ маш том дүгнэлт. Цаашдаа ч гэсэн ер нь бол. Тийм учраас энэ хуулийн дүгнэлтийг бид нар тодорхой гаргасан. Манай Статистикийн газар яаж бодохоор ингээд л инфляц оны эх рүү, сүүл рүү бууна, одоо 8 байна ер нь бараг 5 руу орно гээд яах вэ эерэг төсөөлөл. Гэхдээ энэ эерэг төсөөлөл чинь иргэдэд бодит орлогыг нь нэмэгдүүлэх боломжийг нь хоцроогоод байна шүү гэдэг маш том анхаарлын тэмдэг байгаа. Энэний хариуцлагыг хэн хүлээх юм гэдэг ийм асуудлыг бид нар дүгнэлт өгсөн.

Тийм учраас дор хаяж тэр тэр 10 орчим хувь дээр нь, тэгээд сая манай Сангийн яамныхан хэлж байх шиг байна. Ер нь энэ доод тэтгэврийг нэмье. Эх үүсвэр хамааралтай энэ бол улс төрийн шийдвэр. Ахмадуудынхаа доод тэтгэврийг 1 сая, сая 500 гээд үе шаттай нэмэгдүүлэх шаардлага байна гэдэг энэ ажлын хэсэг дүгнэсэн. Огт ямар ч үндэслэлгүй байна. Энэ ахмадууд сая 500 болгож байгаа нь ямар ч үндэслэлгүй байна гэж огт үзээгүй. Тийм учраас хүний өргөдөл дээр бид нар доод тэтгэврийг үе шаттайгаар сая 500 дээр нь хүрэх зайлшгүй шаардлагатай гээд дүгнэсэн.

Гуравдугаарт, Монголбанкныхан тойруулаад л байх юм даа та хэд маань. Яг ний нуугүй хэлэхэд Монголбанкнаас бичгээр яг тодорхой хариу ирээгүй, Сангийн яамнаас бичгээр ирээгүй. Би харин энэ Өргөдлийн байнгын хороон дээр орж ирж эцсийн мөчид бас үнэнээ хэлж байна. 150 хувийн эрсдэлтэй гээд тавьчихсан нь үнэн шүү дээ. Энийгээ бууруулаад өг, хажууд нь сууж байгаа арилжааны банкууд хэрвээ эрсдэлийн сангийн 150 хувийг бууруулаад өгөх юм бол бид нар зээлийн хүүгээ, эрсдэлийн сангаа багаар байлгаад зээлийн хүүг бууруулахад нөлөөлнө өө.

Заавал байлгах нөөцийн хэмжээ гээд банкнуудын тэтгэвэрт өгч байх ёстой зарим эх үүсвэрүүдийг хэт өндөр тогтоосноос болоод энэ чинь зардал болдог.

Тийм учраас энийг буулгах юм бол бид нарт эх үүсвэр бий болох юм бол тэтгэврийнхээ зээлийн уян хатан нөхцөлийг тавиад өгье гэдэг энэ санал, дүгнэлтээ өгчихлөө. Энэ өөрөө бид нарын олж гаргаж авч байсан арилжааны банкнуудтай ярьж гаргаж ирсэн том дүгнэлт шүү. Яахлаараа тэтгэврийг хамгийн өндөр эрсдэлтэй зээлийн ангилалд оруулчихсан байдаг юм? 50 хувийн эрсдэлтэйд оруулаад ирчихсэн. Буцаан төлөлт нь 97 хувь байж байхад. Тэгээд энэ Монголбанкны энэ эрсдэлийнхээ юун дээр одоо энэ чуулганаас өмнө, дараагийн төсвийн болон юуны Байнгын хороон дээр Монголбанкныхаа тэр мэддэг удирдлагуудаа авчирч ирээд, тэр Лхагвасүрэн ерөнхийлөгчөө авчирч ирээд энэ дээр хариулт өгөөрэй. Энэ өөрөө маш том дүгнэлтийн асуудал гараад байгаа Хэрвээ энийгээ буулгачихъя гэх юм бол арилжааны банкнууд тодорхой хэмжээгээр буулгана гэж байна.

Дээрээс нь Эрүүл мэндийн яам бас бодитой юм ярина нөхөд өө. Та нар яг ахмадуудыг ороод ирэнгүүт нь үндсэндээ эмнэлэгт хэвтье гэж байгаа ахмадуудыг хэдэн хувийг нь хэвтүүлж байгаа юм? Үндсэндээ 5-7 хоног хэвтүүлээд л ЭМД-ын санхүүжилт гацаж байгаа учраас гар гэдэг байдлаар гарч байгаа. Эмнэлэгт хэвтэж сувилуулахын тулд наад хүмүүс чинь тэтгэврийн зээл аваад, хувийн эмнэлгүүдээр өдрийн дор хаяж хоногийн 150 мянган төгрөг хэвтээд байна шүү дээ. Энэ чинь эрсдэлд авчирч ирээд тэтгэврийн зээлийг нь авхуулах нөхцөлийг нь бий болгоод тэтгэвэр хүрэхгүй байна гээд байгаа. Манай сая энэ Алтанзул эгч хэлж байна 600 мянган төгрөгийн тэтгэвэртэй хүн үндсэндээ 3 хоног эмнэлэгт хэвтэх мөнгө байхгүй юу энэ чинь.

Тийм учраас 10 хоног хэвтвэл хүн яаж байна вэ гэхээр 3 сарын тэтгэврийн мөнгө авч байна. Энийг чинь эрсдэлд нөлөөлөөд байна гэж байгаа. Дээрээс нь харин манай Гэр бүлийн яамныхан Ахмадын тухай хууль дээр, асрахуй дээр 7 тэрбум төгрөг тавьсан байна лээ. Өөрөөр хэлбэл гэрээр нь асрах, өдрийн асрах үйлчилгээ гээд. Энийгээ жоохон нэмээд өг өө. Тэгэх юм бол наад ахмадууд чинь тэтгэврийн зээл авч энд тэнд сувилал, эмнэлэг, хувийн эмнэлэг хөөцөлдөхгүй нэг талаараа эрсдэлийг хааж өгч байгаа. Ялангуяа бага тэтгэвэртэй хүмүүс гэдэг ийм дүгнэлтүүдийг тавьсан. Баярлалаа.

О.Номинчимэг: Үг хэллээ. Лувсанжамц гишүүн үг хэлье.

Г.Лувсанжамц: Өдрийн мэнд хүргэе. Өргөдлийн байнгын хороо өнгөрсөн хаврын чуулганаар шинээр байгуулагдсан. Хүнд нь зориулж байгуулсан байсан 4 Байнгын хороог татан буулгасан. Өргөдлийн байнгын хороо үр дүнтэйгээр шуурхай ажиллаж эхэлж байгааг та энэ маань өнөөдөр ингээд харж байгаа болов уу гэж бодож байна. Нийтдээ 7 сарын 9-нөөс хойш ахмадын тэтгэврийг нэмэгдүүлэхтэй холбоотой 14 санал ирсэн. Энэ асуудлыг Өргөдлийн байнгын хорооны дарга Номинчимэг гишүүн ахлаад ажлын хэсэг байгуулъя гээд Эрдэнэбат гишүүн, Рэгдэл гишүүн, Мөнхтулга гишүүдээр ажлын хэсгийн дүгнэлтийг гаргуулж ажиллаж байна гэж харж байна. Тэгэхлээр нийт энэ Өргөдлийн байнгын хорооны чуулганыг үзэж сууж байгаа хүмүүс маань Улсын Их Хуралд хандах юм бол асуудлыг хэлэлцдэг юм шүү. Та бүхний төлөөлөл энд шийдлийг эрэлхийлэх гэж сууж байгаа. Та бүхэн Өргөдлийн байнгын хороонд хандаасай гэж хүсэж байна.

Хоёрдугаарх нь Эрдэнэбат гишүүн ахлагчид ажлын хэсгийг бол богино хугацаанд гэхэд чамлахааргүй их ажил хийсэн байна гэж харж байна. Гэхдээ энэ дээр нэмж хийх ёстой ажлууд байгаа болов уу гэж бодож байна. Нэгдүгээрт та бүхний маань гаргасан саналууд бол олон төрлийн хувилбартайгаар дүгнэлтүүд гаргасан байна. Олон төрлийн хувилбарууд байгааг нь зөв гэж бодож байна.

Нөгөө талдаа Бат-Эрдэнэ гишүүн сая хэлж байсан шийдэл нь юу байх юм бэ хуулийг нь өөрчлөх юм уу, эсвэл Монголбанкны зээлийн журмыг нь өөрчлөх юм уу гэсэн шийдлийнх нь санал нь цуг байх юм бол Өргөдлийн байнгын хороон дээрээ хэдүүлээ хамт саналаа хураагаад тэрийгээ цааш нь Төсвийн байнгын хороонд явуулах гэсэн Өргөдлийн байнгын хорооны хариуцаж байгаа ажлыгаа бодитоор хууль, эрх зүйн орчинд тусгах боломж нь бүрдэнэ гэж харж байгаа.

Гуравдугаарт, маш олон улс төрч нар цалин, тэтгэвэр нэмнэ гэж попордог. Үнэн. Нөгөө талдаа яаж нэмэх гэж байгаа вэ гэдэг орлогынхоо эх үүсвэрийг бас ярих ёстой. Монголбанкийг инфляц хөөрөгдөөд байна гэж яриад загнадаг. Сангийн яамны орлого нь хүрэхгүй байна гээд загнадаг. Би бол төрийн байгууллагынхныгаа өмөөрч хэлмээр байна. Энэ хэд маань улс төрчдийн гаргасан чиглэлийн дагуу л ажлаа хийдэг. Хамаагүй бас тэгж хүйтэн, хатуу үгээр хандаж болохгүй болов уу гэж бодож байна. Төрийн албан хаагч нар бол бодлогоо бариад л явж байгаа.

Тэгэхлээр улс төрчид маань өөрсдөө эдийн засгийн мэдлэгтэй байх, төсвийн орлогыг нэмэгдүүлэх, инфляцыг яаж тогтвортой байдалд аваачих юм гэсэн энэ зүйлүүд дээрээ шийдвэрээ гаргах ёстой. Төсвийг хэлэлцэж байгаа энэ цаг хугацаан дээр бид нар яаж ирэх жилийн инфляцыг хөөрөгдөхгүй байхаар төсвийн хэмжээг тодорхойлох юм. Энэ цалин, тэтгэврийг нэмэх боломжийг эрэлхийлсэн орлогыг их нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээний хөрөнгө оруулалтыг яаж шийдэх юм гэсэн тийм талд нь шийдлүүдээ гаргаад явах ёстой. Өмнөх хаврын чуулганаар бүгдээрээ хэрүүл хийсэн. Тойргийн гишүүд болгонд 15 тэрбум төгрөг байгаа. Тэрүүгээр хөрөнгө оруулалтаа хийнэ гэсэн ийм байдлаар улсын төсвийн орлогыг нь жалга довын үзлээр бага багаар тараагаад явах юм бол бид нарын төсвийн орлого ч нэмэгдэхгүй, цалин, тэтгэвэр нэмэгдэх боломж нь ч үүсэхгүй.

Тэгэхлээр 126 гишүүд маань санал нэгтгэйгээр орлого нэмэгдүүлэх тал дээр хөрөнгө оруулалтын арга хэмжээнүүдийг бодох хэрэгтэй байна. Хувийн хэвшлүүдийн орлогыг нэмэгдүүлэх, борлуулалтыг нэмэгдүүлэх, төсөл, арга хэмжээний хөрөнгө оруулалтыг нь шийдэж өгөх ёстой. Энэ дээр бас хамтраад Өргөдлийн байнгын хороо маань манлайлалтайгаар ажиллаад бусад Байнгын хорооноос ялгарч чадахаар үйл ажиллагаа явуулж чадах болов уу гэж миний хувьд харж байгаа. Тэгээд өнөөдөр хүрэлцэн ирж мэдээлэл өгсөн та бүхэндээ баярлалаа. Сая хэлсэн шийдлүүд нь юу байх юм, аль хуулийг яаж өөрчилбөл, аль заалтыг хэрхэн өөрчилбөл ямар үр дүн гарах вэ гэдэг боломж, бололцооны шийдлийгээ хэдүүлээ хамтдаа ярилцъя гэсэн саналтай байна.

О.Номинчимэг: Баярлалаа. Пунсалмаа гишүүн. Бадамдоржийн Пунсалмаа гишүүн үг хэлье.

Б.Пунсалмаа: Баярлалаа. Ахмадуудын тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн асрал үйлчилгээг сайжруулах, зээлийн хүүг бууруулах талаар Өргөдлийн байнгын хороон дээр бид нар хэлэлцэж байгаа юм. Ахмадууд маань энэ ордны гадна талд бас 40 гаруй хоног суулт зарлаж тэмцлээ илэрхийлсэн. Тэрний үр дүнд нь 6 хувь орчмоор энэ тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх

боломжтой байна гээд ингээд яамнуудаас мэдээлж байна л даа. Тэр 6 хувь гэдэг нь өөрөө төсөв дээр 378 орчим тэрбум төгрөгийн ачаалал орж ирэх юм. Хэрвээ 8 хувь болгох юм бол 844 тэрбум төгрөг. Энэ бол бас тийм ийм бага бас ачаалал биш л дээ төсөв дээр. Гэхдээ нэгж тэтгэвэр авагч хүн дээр бол энэ их бага тусаад байгаа юм жишээлбэл. Бүүр бага тэтгэвэр авдаг жишээлбэл 689 мянган төгрөгийн тэтгэвэр авч байгаа хүнд 50-иадхан мянган төгрөг нэмэгдэх нь байна л даа. Өндөр тэтгэвэр авдаг хүмүүс дээр нь өндөр нэмэгдэх нь.

Тэгэхлээр ингэж бид нар энэ процентоор нэмж болохгүй нь байна. Ерөөсөө 689 мянган төгрөгийн тэтгэвэр авч байгаа хүмүүс дээрээ бид нар дор хаяж 150, 200-гаад мянган төгрөг байж байж энэ амьдралд арай дөмөгхөн мэдрэгдэж орж ирнэ. Өндөр тэтгэвэр 2 сая төгрөгөөс дээшээ тэтгэвэр авч байгаа хүмүүсийг нэмээд хэрэггүй шүү дээ. Яах вэ хэрэгцээтэй мэдээж. Гэхдээ өнөөгийн яг энэ хязгаарлагдмал боломжийн хүрээнд хамгийн түрүүнд бид нарын хийж болох юм нь энэ бага түвшиндээ байгаа иргэдийнхээ тэтгэврийг нэмэгдүүлэх тал дээр анхаарвал зүгээр биш үү гэдэг энэ саналыг хэлэх гээд байгаа юм.

Цаашлаад энэ ахмадын асралын төв гээд бид нар бас байгуулах боломжийг бас эрэлхийлээд байгаа. Ахмадын тухай хууль дээр бол энэ ахмадын асралын төв дээр төрөөс татаас олгож байгаа. Энийг бас манай энэ төр хувийн хэвшил илүү энэ тал дээр ажиллах, нэмэгдүүлэх, энэ төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өсгөх тал дээр энийг хувь компаниудад илүү ойлгуулах, сурталчлах, хэлэх тал дээр энэ манай яамнууд ажилламаар байгаа юм. Уул нь энэ бид нарын хууль дээр бол энэ ийм асралын төвүүдийг хувийн компаниуд байгуулах энэ боломж нь нээгдчихсэн байгаад байгаа юм л даа. Гэхдээ хараахан ийм компаниуд их цөөхөн байгаад байна.

Цаашдаа бол жил болгон төсөв дээр бас энэ Ахмад, гэр бүл хөгжлийн төвүүд гээд байгуулагдчихсан байдаг юм. Энийг ч гэсэн бас ахмадуудын асралын төв болгож хувиргах энэ тал дээр бид нар бас цаашдаа ажиллах хэрэгтэй байна. Баярлалаа.

О.Номинчимэг: Баярлалаа. Чинбатын Ундррам сайд үг хэлье.

Ч.Ундрам: Ахмадуудын тэтгэврийг нэмэхээр хэн баярладаг гээч арилжааны банкнууд л баярладаг. Яагаад гэвэл бүгдээрээ очоод зээл авч байгаа юм л даа. Тэгэхээр өнөөдөр 2025 оны 6 сарын 30-ны өдрөөр 1.6 их наяд төгрөг арилжааны банканд тэтгэврээ барьцаалаад зээл авчихсан байгаа. Ер эргэн төлөлт нь 97, 98 хувттай ийм эрсдэлгүй зээл учраас банкнууд л баярладаг байхгүй юу. Эрсдэлгүй зээл авах хүмүүс ихсэж байна. Тэгэхээр бид нар энэ тэтгэврийг ахмадууд маань боломжийн амьжиргаагаа аваад явчих хэмжээнд болгож байж л энэ зээл авах байдал нь буурна. Тэрнээс тэтгэврийнхээ тэдэн хувиар л та хэд зээл ав гээд ийм журам Монголбанкнаас гаргачих юм бол эргээд л ахмадууд дээр бухимдал үүсгэж байгаа юм. Өнгөрсөн парламентад бид нар Нийгмийн даатгалын багц хуулийг хэлэлцэж бас энэ тэтгэврийн асуудлыг бүхэлд нь харах гэж нэлээн хичээсэн. Гэхдээ энэ дээр бид нар хэдэн алдаа гаргасан юм. Нөгөө улс төрчдийн попрол гэдэг юмнаасаа болоод.

Нэгдүгээрт энэ Нийгмийн тэтгэврийн сан гэдэг юмаа бид нар өөрөөр нь амьдрах чадваргүй болгоод байгаа юм. Ажил хөдөлмөр 20 жил ч юм уу 30, 40 жил хийсэн хүн шударгаар тэтгэврээ авдаг энэ тогтолцоо руу бид нар шилжиж чадахгүй байгаа юм попролоосоо болоод. Тэгээд л ахиад л нөгөө 7 жил НДШ

төлчих юм бол дахиад 20, 30 жил тэтгэвэр авах боломжийг хүмүүст олгоод байгаа юм. Уул нь шударга тогтолцоогоо нэвтрүүлчих юм бол бүгдээрээ яг ямар хэмжээний цалин хэдэн жил төрд ажиллаад НДШ-ээ төлсөн тэр хэрээрээ тэтгэвэр авдаг ийм шударга тогтолцоо байсан бол ахмадууд маань би сайн ажил хийгээд нийгмийн даатгалаа төлсөн учраас ийм хэмжээний тэтгэвэр авч байна гээд сэтгэл хангалуун ийм байх боломжийг нь бүрдүүлчих юм.

Тэгэхээр одоо энэ 7 жилийн асуудал, малчдын 50 хувь, тэгээд халамжийн тэтгэвэр гэсэн ийм 3 яг ийм халамжийн чиглэлийн асуудал байгаа. Тэгэхээр энийгээ бид нар эргээд Тэтгэврийн сангаа, Нийгмийн даатгалын багц хуулиа бүхлээр нь харах хэрэгтэй. Дээрээс нь дэлхий нийтээрээ тэтгэвэрт гардаг нас нэмэгдэж байгаа. Яагаад гэвэл дундаж наслалт нэмэгдээд байгаа. Манай улсад яах вэ бага багаар хэдэн сараар нэмэгдэж байгаа л даа.

Гэхдээ л ер нь 55, 60 хэвээрээ байгаа. Тэгээд олон хүүхэд гаргах юм бол эрт гарч байна тэтгэвэрт. Хууль хүчний байгууллагын хүмүүс эрт гарч байна. Тэгэхээр энэ тогтолцоог бид нар шударга болгох цаг нь болсон. Ингэж байж энэ ахмадууд байсхийгээд л энэ гадаа хүйтэнд жагсдаг энэ асуудал байхгүй болох юм. Тэгээд нийгмийн даатгалын багц хуулиа бид нар ярихдаа нийт ахмадын хуулиа хамтад нь бас уул нь ярих ёстой байсан юм байна лээ. Ар араас нь ярьчихсан.

Тийм болохоор энэ ахмадуудын хэрэгцээ шаардлага, энэ нийгмийн асуудлуудыг нь бид нар бүхэлд нь харж байгаад Нийгмийн даатгалын багц хууль, мөн Ахмадын хууль гэдгээ нэг дор ярьсан бол энэ хүмүүс өнөөдөр энэ бухимдаад суухгүй. Тэгэхээр энэ Байнгын хороогоороо ч юм уу бид нар яг ингэж бүхэлд нь судалгаа хийлгээд, бүхэлд нь энэ хуулиудаа ер нь харах ёстой. Өнөө маргаашдаа магадгүй гал дарах байдлаар Төсвийн байнгын хороотойгоо ярьж байгаад ойр зуур нэмэх асуудал л шийдэж чадна. Тэрнээс илүү дорвитойхон тогтолцооны шинэчлэлийг бид нар өнөө маргааш хийж чадахгүй. Ийм л саналтай байна.

О.Номинчимэг: Ундрам сайдтай бас санал нэг байна. Энэ яах вэ бид нар энэ жил ингээд төсвийн хэлэлцүүлэгтэй давхцаж байгаа учраас энэ дээр аль болох шийдчих юм сан л гэдэг байдлаар явж байгаа боловч энэ уг үндсээр нь шийдэж байгаа шийдэл болохгүй. Тэгэхээр энийг бас шийдэхэд илүү улс төрийн ч, манай төрийн албан хаагчдын ч зоригтой, чамбай ажил, зоригтой үйлдлүүд бас хэрэгтэй болох учраас түрүүн манай Бат-Эрдэнэ гишүүн ч хэлж байна, Лувсанжамц гишүүн маань ч хэллээ, Ундрам сайд ч гэсэн хэлж байна яг хуульдаа үнэхээр байгаад байвал хуулийг нь өөрчлөх талаар бид ч гэсэн бас Өргөдлийн байнгын хороо ч гэсэн энэ асуудал дээр анхаараад ийм уг үндсээр нь симптомтой нь биш учир шалтгаантай нь тэмцэж арилгах тал дээр илүү бас анхаарах ёстой гэдэг дээр санал нэгдэж байна.

Мөнхбаясгалан гишүүн үг хэлье.

Л.Мөнхбаясгалан: Хангалттай сонслоо. Сайд орж ирж үгээ хэлсэн. Яг энэ өнөөдрийн энэ тогтолцоогоор, өнөөдрийн энэ төсвөөр бид ахмадуудынхаа тэтгэврийг нэмж чадахгүй нь тодорхой л доо. Яаж ч тэтгэвэр нэмье гэж манай энэ ажлын хэсгийнхэн дүгнээд ч бид нар 40 гаруй гишүүн гарын үсэг зураад ч чадахгүй, энэ тогтолцоогоор чадахгүй. Энэ манай банкныхан, Сангийн яамныхан хэлж байгаа ч үнэн. Одоо байгаа нь энэ нэмж чадахгүй. Гэхдээ хэрвээ нэмье гээд ажиллавал болдог гэдгийг Монголын төр 1 удаа харуулсан байдаг. Тэр Салхитын мөнгөний ордоор ахмадын тэтгэврийн зээлийг 1 удаа тэглэсэн. 6 сая хүртэлх

ахмадын өртэй ахмадуудын зээлийг тэглээд зээлгүй байсан ахмадуудад сая сая төгрөг өгсөн шүү дээ. Энэ тийм эргэлтийн шинжтэй зоримог алхам л хийж байж бид нар ахмадын тэтгэврийг 1 сая 500 мянган төгрөгт хүргэж чадах юм.

Тэгэхээр тэгэх сэтгэлтэй, тэгэх зоригтой тийм зүйлийг олж хардаг хүн өнөөдрийн энэ төрд байхгүй байна. Уучлаарай тийм учраас чадахгүй байгаа юм. Ахмадууд маань гуйж байна л даа доод тэтгэврийг 1.5 сая төгрөг болгоод өгөөч гэж. Улсын Их Хурлын гишүүд мэдэж байгаа. Бид тойрогтоо 10 хоног ажиллахад 1.5 сая төгрөг бараг зарлагадаад ирдэг. Бензин, явсан зардал, бүх юмандаа ийм байдаг. Гэтэл энэ хүмүүс чинь бүтэн 1 сар амьдардаг хөөрхий. Тэгээд 92.5 хувь нь нийт ахмадуудын ийм ядуу амьдарч байгаа ерөөсөө л ядуурал руу живчихсэн ийм л байгаа юм. Тэгээд энийг ойлгохгүй гишүүд байна гэж байхгүй л дээ. Бүгдээрээ л ойлгож байгаа, бүгдээрээ л санаа нь зовж байгаа.

Гол нь тэр зоримог реформыг л хийж чадахгүй байгаа байхгүй юу. Тийм юм төрд 1 удаа л тохиолддог юм шиг байна л даа. Тийм хүн байгаасай. Тэгэх юм бол чадна. Тэгэхгүй бол чадахгүй. Тэгэхээр Засгийн газар уг нь энийг хийгээд ярих ёстой байхгүй юу. Бид нар хаанаас эх үүсвэр олох вэ? Тухайн үед Салхитын мөнгөний орд гээд газрын зураг дээр байдаггүй жижигхэн мөнгөний ордоор Ахмадын тэтгэврийн зээлээ тэглэж чадаж байсан байхгүй юу. 900 тэрбум төгрөг шүү дээ тухайн үед тэгж хийж байсан юм. Тэгэхээр Засгийн газар энийг хийх ёстой. Тэгээд хийхгүй л байна л даа. Огцрох, огцрохгүй асуудал нь чинээнд нь тулчихсан тэгж ажиллах сонирхол байхгүй ийм л байгаа юм. Үнэн нүүр царай нь л ийм. Ингэж ярьж байгаадаа харамсаж байна. Яг энэ байгаа байдлаар бол чадахгүй. Тэгэхээр ийм зоримог алхам хийх ёстой, асуудлыг олж харах ёстой, эрх барьж байгаа нам энийг хийх ёстой, Засгийн газар энийг хийх ёстой юм.

О.Номинчимэг: Гишүүд үг хэлж дууслаа.

Энэ асуудлыг бас Нийгмийн, хөгжлийн байнгын хороо, Хүний хөгжлийн байнгын хороо, Төсвийн байнгын хороо хамтарсан байдлаар дахиж бас хэлэлцэх гэж байна. Тэгэхээр Өргөдлийн байнгын хорооны хувьд ямар ч байсан ажлын хэсгийн санал, дүгнэлттэй танилцаад хэлэлцлээ. Тэгээд зарчмын хувьд дэмжээд энэ 2 хороонд ер нь танилцуулж цаашид мэдээж энэ төсвийн ажлын хэсэг, Төсвийн байнгын хорооны дарга Засгийн газартайгаа хамтарч ажиллаад ямар шийдлүүд байх вэ гэдгийг бас эрэлхийлэхээр байгаа гэдгийг Сангийн яам түрүүн хэлсэн. Тэгэхээр энэ томьёоллоор санал хураая гэж өнөөдрийн ч хуралдаанд бэлтгэсэн байна.

Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг зарчмын хувьд дэмжиж, Хүний хөгжил, нийгмийн бодлогын болон Төсвийн байнгын хороонд шилжүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураая гэж байна. Энэ дээр томьёолол дээр саналтай гишүүн байвал хэлчих тэгэх үү?

Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Үгүй яах вэ шилжүүлэхээр чинь тэгээд л шийдэхгүй шүү дээ. Ойлгомжтой асуудал байхгүй юу. Миний санал, горимын санал бол саяын 2 хороотой хамтарсан хурлыг 1 удаа хийх нь зөв байх манай Өргөдлийн байнгын хорооноос. Манай Өргөдлийн байнгын хороо үнэхээр ард түмнийхээ төлөө гээд, ахмадуудынхаа төлөө гээд, багш, эмч нарынхаа төлөө гээд ирсэн өргөдөл, гомдлыг эцэслэн шийдвэрлээ гэж бодож байгаа бол энэ Байнгын хороон

дээр ороод энэ Өргөдлийн байнгын хороонд гишүүнээр ажиллаж байгаа Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооныхоо ирсэн өргөдлийнхөө талд зогсоод энэ асуудлыг шийдвэрлэхийн төлөө байх ёстой.

Тэгэхгүй бол зүгээр шилжүүлэхээр тэнд боломжгүй гээд л буцаачих байхгүй юу. Хэдүүлээ бас муу ч сайн ч жил гаран энэ парламент дотор суулаа. Үнэртэж байна шүү дээ. Бүх юм чинь үнэртэж байгаа юм. Тэгээд энийг бол миний хувьд бол ийм томъёоллоор санал хураалгаж өгөөч. Аль нэг гарцыг олохын төлөө, шийдлийн төлөө хэдүүлээ ажиллацгаая. Зүгээр хий утаа май тавиад өнгөрөөхгүй байя гэдэг ийм саналыг оруулж байгаа юм.

О.Номинчимэг: Тэгвэл санал хураахгүй хэлэлцэж дууслаа гээд ер нь бол санал хураах юм уу? Дэмжихээрээ өгөөд тэгээд хамтарсан Байнгын хороонд оръё. Бас Төсвийн ажлын хэсэгт энэ асуудлыг барьж орох гишүүнээ Төсвийн ажлын хэсэгт оруулах саналаа өгье тээ? Тэгээд энийгээ мэдээж энэ чинь төсөв, мөнгөтэй л холбоотой юм чинь ийм байдлаар.

Тэгвэл ажлын хэсгийн санал, дүгнэлтийг зарчмын хувьд дэмжиж, Хүний хөгжил, нийгмийн бодлогын болон Төсвийн байнгын хороонд хороонд уламжлах нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураах уу болж байна уу? Санал хураалтдаа бэлдье гишүүд.

Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг зарчмын хувьд дэмжиж, Хүний хөгжил, нийгмийн бодлогын болон Төсвийн байнгын хороонд уламжлах нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явъя.

Санал хураалтад нийт 81.3 буюу 13 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Ажлын хэсгийн санал дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Өргөдлийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо, Төсвийн байнгын хороонд Бат-Эрдэнэ гишүүн танилцуулах уу? Эрдэнэбат гишүүн танилцуулах уу? Өөрөө ажлын хэсгийн санал, дүгнэлт Эрдэнэбат гишүүн танилцуулна.

11.15 цаг

Дараагийн асуудалд оръё. Уучлаарай одоохон ганцхан мэдээлэл сонсоод Байнгын хорооны үйл ажиллагаатай. Манай гишүүдийн гаргаад байгаа Өргөдлийн байнгын хороо чинь тэгвэл ямар үүрэг рольтой, манлайлалтай ажиллах вэ гэдэг дээр та бүхэнтэйгээ бас бас өнөөдөр, одоогийн ирсэн өргөдлүүдийн дүн шинжилгээ, анализ, **Байнгын хорооны өөрийн дотоод дүрэм буюу өргөдлүүдийг яаж, хэрхэн шийдвэрлэж байх тухай төсөл.**

Манай Тамгын газраас болон ажлын албанаас бэлдсэн байгаа юм. Та бүхэнд тарааж өгсөн байх. Байнгын хорооны дотоод зохион байгуулалтын талаар танилцуулах асуудал орж байна.

Гишүүддээ бас хэлэхэд манай Байнгын хороо шинээр байгуулагдаад бид бас сайн жишиг нь юу юм, яг энэ иргэдийнхээ дуу хоолойг бодлого, шийдвэрт үр дүнтэй гаргах дээр тэгвэл Байнгын хороо ямар үүрэг рольтой ажиллах ёстой юм бэ гэдэг дээр бол ер нь бас тогтож сууж гишүүдийнхээ саналыг бас сонсох ёстой байгаа. Тэгээд өнөөдөр бол эхний байдлаар та бүхэнд боловсруулсан Байнгын

хорооны дүрмийг танилцуулсан, хүргүүлсэн байгаа. Өргөдөл орж ирэхээр яаж хариуцаж ямар үйл ажиллагаа хийгдэх вэ, ямар үед Байнгын хороогоор оруулах вэ гэдэг асуудлууд байгаа.

Дээр нь өмнөх 12 онд байгуулагдсан Өргөдлийн байнгын хороо Бурмаа даргаар ахлуулж байхдаа бас энэ Германы туршлагыг судлаад чиглэл чиглэлээр гишүүдээ хувааж яг энэ чиглэлийн өргөдлүүд орох юм бол тухайн гишүүд маань өөрсдөө бас хариуцаж, судалж иргэдийнхээ хойноос энэ асуудлуудынх нь хойноос явж Байнгын хороондоо танилцуулж шийдвэрлэдэг илтгэгч гишүүнийг томилдог ийм практикийг бас авч хэрэглэж байсан. Тэгэхээр бид бас энийг авч хэрэгжүүлэх нь зүйтэй болов уу гээд 4 чиглэлд хуваасан байгаа.

Аюулгүй байдал, гадаад бодлого, төр, хууль эрх зүйн асуудлын нэгдүгээр асуудал.

Хоёрдугаарт байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуй, хот байгуулалт, барилга, зам тээвэр, эрчим хүчний бодлогын асуудал.

Гуравдугаарт хүний хөгжил, нийгмийн бодлогын асуудал, эдийн засаг, төсөв, аж үйлдвэр, эрдэс баялаг, цахим хөгжлийн бодлогын асуудал гээд ер нь яамнуудынхаа чиглэлээр болон бусад Байнгын хороодынхоо чиглэлээр энэ асуудлууд дээр илүү төвлөрч ажиллая гэсэн ийм 4 чиглэлд хуваагдаад энэнтэй холбоотой өргөдлийг тухайн гишүүд, бид нар бол илтгэгч гишүүнээр Германы туршлага бол заавал эрх барих хүчин, сөрөг хүчнээс хүн гээд 2 хүнд заавал даалгаж өгдөг. Энэ 2 өөрсдөө аль аль талаас нь хараад ялангуяа бид нарын өргөдөл бол Өргөдлийн байнгын хороонд ирж байгаа өргөдөл дандаа Засгийн газрын хууль хэрэгжилттэй холбоотой, эсвэл орон нутагтай холбоотой энэ асуудлууд ирдэг учраас ийм баланстай байдаг гэдэг энэ зарчмаар байгаа.

Тэгэхээр энэ дээр гишүүд маань бас бодоод саналаа Байнгын хорооны ажлын албанд аль сегментэд харьяалагдаж энэ чиглэлийн өргөдөл дээр ажиллахыг хүсэж байна гэдгийг бас өгвөл их зүгээр байгаа. Энэ удаа ажлын албаны ахлах зөвлөх Наранцэцэг Өргөдлийн байнгын хороон байгуулагдсанаас ирсэн өргөдөл, гомдлын тоймыг та бүхэнд бас товч танилцуулъя. Тэгээд энэтэй холбоотой мэдээж манай гишүүд маань байвал асуулт асууж, бас үг хэлж, саналаа хэлэх энэ боломжоор хангая гэж бодож байна.

Наранцэцэг ахлах өргөдөл, гомдлын тоймоо танилцуулчих уу?

Д.Наранцэцэг: Гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе.

Өргөдлийн байнгын хороо 2025 оны 7 сарын 9-нд байгуулагдсанаас хойших хугацаанд нийт 61 өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг ирүүлсэн байна. Үүнийг агуулгаар нь ангилбал ахмадын тэтгэврийг нэмэх, тэтгэвэр зөрүүтэй бодогдсон талаар 14 өргөдөл ирсэн байна. Эмч, багш нарын цалинг нэмэх 6, хүний эрхийн зөрчил, Эрүүгийн хуулийн өөрчлөлтийн талаар 9, хууль, эрх зүй шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн талаар 7, Боловсролын салбар, Боловсролын зээлийн сангийн талаар 4, төсвийн асуудлаар 2, хот төлөвлөлт, хот зохион байгуулалт, барилга, орон сууцжуулалтын талаар 10, шагнал хүсэх 2, аж үйлдвэр, эрдэс баялгийн асуудлаар 3, хилийн цэсийн маргааны асуудлаар 2, Их Хурал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагаатай холбоотой 2 гэсэн ийм нийт 61 өргөдөл, гомдол Байнгын хороонд ирсэн байна.

Үүний хүрээнд бол 8 өргөдлийг шийдвэрлэн хаасан ба судлан шийдвэрлэх шатад явж байгаа өргөдлүүдээс та бүхэн мэдэж байгаа Байнгын хорооны хурлаар хэлэлцүүлсэн эмч, багш нарын цалинг нэмэгдүүлэхтэй холбоотой ирсэн 6 өргөдлийг хэлэлцээд Байнгын хорооны санал, дүгнэлтийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо, Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн байгаа.

Ахмадын тэтгэвэр нэмэгдүүлэх 10 өргөдлийн асуудлыг бид бас 9 сарын 30-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцээд ажлын хэсэг байгуулаад, өнөөдөр бас ажлын хэсгийн санал, дүгнэлтээ хэлэлцээд холбогдох Байнгын хороод болон төсвийн ажлын хэсэгт хүргүүлэхээр Байнгын хорооны гишүүд маань дэмжээд ажиллагаа хийгдээд явж байна.

РЦНК буюу Оросын Соёл, шинжлэх ухааны төв орчмын 3 га газрын ногоон байгууламжаар нь үлдээх 4 мянга гаруй оршин суугчдын төлөөллийн өргөдлийн талаар талуудыг оролцуулж албан уулзалт зохион байгуулсан. Энэ дээр бол хугацаатай үүрэг даалгавар өгсөн. 14 хоногийн хугацаатай үүрэг даалгавар өгсөн хариуг хүлээж байгаа.

Нийт шийдвэрлэлтийн явцад байгаа 37 өргөдлөөс холбогдох төрийн байгууллага албан тушаалтан тодруулга, тайлбар албан бичгээр хүссэн 28 байна. Өргөдөл гаргагчаас нэмэлт мэдээлэл хүссэн 2 байна. Ажлын албаны хэмжээнд судлагдаж байгаа 7 гэсэн ийм явцтай байна.

Нийтийн өргөдөл, гомдлын талаар мөн цахим системд нийт 132 өргөдөл, гомдол ирснээс Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан шаардлага хангасан 21 өргөдлийг цахим системд байршуулсан. Үүнээс 2 өргөдөл хуульд заасан иргэдийн дэмжлэгийг авч Улсын Их Хурлын хурлаар хэлэлцэгдэж байгааг та бүхэн маань мэдэж байгаа.

Монгол Улсын Засгийн газрын 11-11 төвөөр бас Улсын Их Хурлын дарга болон удирдлага гишүүдэд нийт 33, Их Хурлаас удирдлага нь томилогддог байгууллагуудад 83, нийт 116 өргөдөл, гомдол ирснийг бас бүртгэж, холбогдох албан тушаалтанд нь уламжилсан байна.

Танилцуулж дууслаа. Баярлалаа.

О.Номинчимэг: Бидний хувьд бол хийх ажил их юм байна лээ. Бид бас Байнгын хорооны ажлын алба ер нь энэ Өргөдлийн байнгын хороо яаж зөв авч явах вэ, яаж үр дүнтэй ажиллах вэ гэхэд дэд бүтцийн асуудлаас өргөдлөө хэрхэн, яаж ялгаж ангилж шийдвэрлэлтийг нь хойноос нь харах энэ систем ч байхгүй байгаа ер нь боловсронгуй. Энийг бид нар яг ямар түвшинд шийдэж байх гэдэг энэ журмыг бол эхний байдлаар бас ингээд боловсруулаад та бүхэнд тараасан байгаа. Тэгэхээр энэтэй холбоотой хэрвээ та бүхэн маань бас танилцаж амжсан бол эрхний энэ чинь санал хэлэх бол санал хийгээд өнөөдөр тийм санал хэлэх.

Асуулт асууж, санал хэлэх үг хэлэх гишүүд нэрсээ өгье.

Мөнхбаясгалан гишүүнээр тасаллаа. Бат-Эрдэнэ гишүүн асуулт, үг санал.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Энэ Өргөдлийн байнгын хорооны жоохон шийдэл рүү явуулахгүй бол манайх ингээд өнгөрсөн хугацаанд хараад байхаар

дамжуулагчийн үүрэг гүйцэтгэдэг болчих вий дээ гэдэг санаа зовнил байна. Өөрөөр хэлбэл өргөдөл ирдэг. Бид нар хэлэлцсэн асуудлаа дэмжсэн, дэмжээгүйгээрээ дараагийн Байнгын хороо руугаа шилжүүлдэг. Улсын Их Хурлын дээр нэгдсэн чуулганы хуралдаан ч юм уу, бүтцийн байгууллагуудын хувьд бол мэргэжлийн Байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэнэ гэж их ярьдаг. Манайх ч мэргэжлийнх гэдэг рүү нь аль руу нь ч орохгүй болчихоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр өөрсдийнхөө энэ Өргөдлийн байнгын хороон дээр авч хэлэлцэж байгаа асуудлууд, бид нар энэ өргөдөл гаргагчаас нэмэлтээр тайлбар, тодруулга авч байгаа, нэмэлт мэдээллүүд авч байгаа, эргээд сонсож байгаа. Тэгээд тодорхой хэмжээний шийдвэрүүдийг бид нар гаргаж байгаа. Эргээд Байнгын хороонууд хоорондын уялдаа холбоотой асуудал дээр миний түрүүний хэлсэн санал буюу тодорхой хэмжээнд энэ дүрмийн 4.4 дээр өргөдөл түүнд дурдсан асуудлыг шийдвэрлүүлэхээр бусад Байнгын хороонд шилжүүлэх шаардлагатай гэж үзвэл Байнгын хороо хэлэлцэн санал, дүгнэлт гаргаж, холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ гэж байгаа юм.

Тэгээд хүргүүлэхээр нөгөө мэргэжлийн Байнгын хорооных нь санал, дүгнэлт давамгайлчих гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нарын хувьд бол энэ дээр аль болох Байнгын хорооныхоо санал, дүгнэлтийг хамгаалах чиг баримжааг барих, үнэхээр нөгөө ирж байгаа өргөдөл дээр тэр өргөдөл гаргагч этгээдүүдийн үзэл баримтлал, бодол санаа, хамгаалалт нь бид нар болчихоод байгаа байхгүй юу ний нуугүй хэлэхэд. Тэгэхээр тэр өргөдөл гаргагч нарыгаа хамгаалдаг системээ бид нар энэ дотроо хийж өгөхгүй бол болохгүй юм шиг санагдаад байгаа юм. Мөнхтуяа гишүүний нэг талдаа хэлж байгаа үнэн л дээ. Бид нар ингээд тойрч суугаад л бүгдээрээ л хуралдаад л байдаг, хуралдаад л байдаг, эцсийн шийдэл байдаггүй. Лука гишүүн маань Лувсанжамц гишүүн маань бас хэлж л байсан. Бид нар ерөөсөө гарц шийдэл хайхгүй байна. Зүгээр л хурлаас хурлын хооронд л явж байна. Тэгэхээр хэдүүлээ гарц, шийдэл рүүгээ ормоор байгаа юм. Тэгэхээр энэ Өргөдлийн байнгын хорооны ажиллах дүрмийг гарц шийдэл тал руу нь жоохон редакцын засвар хийж өгөөч гэдэг ийм саналыг дэвшүүлэх гэж байгаа юм. Баярлалаа.

О.Номинчимэг: Баярлалаа. Мөнхбаясгалан гишүүн.

Л.Мөнхбаясгалан: Энэ юун дүрэм болоод явчлав. Өмнө нь Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд ажиллаж байсан. Ийм дүрэм байгаагүй шүү дээ. Дүрэм гаргаад л, журам гаргаад л ингээд байх тусмаа л хүнд суртал чинь нэмэгдэнэ. Тэгээд энэ Өргөдлийн байнгын хорооны гишүүдийн хариуцах салбарын хуваарь гэж байна. Энэ бид нар ингэж салбар хариуцах юм уу тээ? Энэ хэрэггүй. Миний бодлоор энэ дүрэм чинь ч хэрэггүй, энэ гишүүдийн хариуцах салбар гэж ингэж Их Хурлын гишүүдийг хайрцаглах ерөөсөө хэрэг байхгүй. Нээлттэй л байж байсан нь дээр. Энэ ирж байгаа өргөдлүүдийг соортлоод, ангилаад хэлэлцүүлэх асуудал бэлтгэх чинь энэ Байнгын хорооны ажилчдын хийх ажил мөн. Бид нарын хийх ажил биш байхгүй юу. Би нэгдүгээрт тэгж бодож байна. Дүрэмтэй болоод л, журамтай болоод л энэ Өргөдлийн байнгын хороонд асуудлын загвар энэ яах юм энэ хэрэггүй шүү дээ. Хүн ер нь юугаар ч явуулж болно. Энэ ийм улам л хүнд суртал шат дамжлага битгий нэм ээ. Энэ хэрэггүй. Хэдүүлээ зүгээр задгай л байя. Тэгэхдээ ганц анхаарах юм нь түрүүний Бат-Эрдэнэ гишүүний хэлдгээр бид мэргэжлийн Байнгын хороо байх ёстой байхгүй юу.

Тэгэхээр Дэгийн тухай хуульдаа өөрчлөлт оруулах асуудлаа яаравчлах хэрэгтэй. Тэгж байж бид нар хүчтэй болно. Тэгж байж ард түмнийхээ асуудлыг шийдвэрлэхэд энэ Өргөдлийн байнгын хороо ингэсэн байна шүү гэдэг асуудал гарч ирж ард түмэн бид нарт хандаж, бид нараас аврал, тусламжаа ирдэг л болох ёстой.

Тэгэхээр Номио дарга энэ яах вэ ажил хэрэгч хүний зан би ойлгож байна. Гэхдээ энэ дэмий. Би бол энийг дэмжихгүй байна манайхан. Бид нар энэ дүрмээр яах юм, бид нар энэ журмаар яах юм? Дүрэм, журмаас их юм Монголд алга байна шүү дээ. Тэгээд Өргөдлийн байнгын хороонд юм бичихийн тулд ийм маягт бөглөж яах юм бэ? Зүгээр л ямааныхаа бэлчээр дээрээс л олдсон цаасан дээрээ, нойлын цаасан дээр ч хамаагүй бичээд л явуулаг л дээ. Бид нар тэрийг нь аваад л ярьчихъя л даа. Би бол тэгж л бодож байна.

О.Номинчимэг: Тэгээд энэ Мөнхбаясгалан гишүүнээ наад ард талын форум ерөөсөө өргөдөл гаргагчид хамаатай юм биш. Өргөдөл гаргагчид ямар форумар яах вэ гээд хуулиараа угаасаа нээлттэй. Энэ бол Байнгын хороо гарсан өргөдлүүдийг, агуулгыг нь, ажиллагааг нь юу хийх вэ гэдгийг бүгдийг нь тоймлоод одоогоор бол Байнгын хорооны ажиллагаа чинь ингээд үгүй үгүй энэ бол ерөөсөө гишүүдэд ийм өргөдлүүд хийгээд, ийм ажиллагаа хийгээд, ийм шийдвэрүүд гарч байна шүү гэдгийг тайлагнах форум юм. Дүрмийн хувьд энэ ерөөсөө тэр бусад иргэдэд үйлчилж байгаа хэм хэмжээний акт биш. Ерөөсөө манай дотоод үйл ажиллагаатай холбоотой тийм юм байхгүй юу. Дотоод үйл ажиллагаатай ийм дүрэм байхгүй бол миний үзэмжээр болчих гээд байна яг үнэнийг хэлэхэд. Нэг хүнээс хамааралтай тийм үзэмжээр болчих гээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр энийг биш манайх дотогшийгоо чиглэсэн зохион байгуулалтын юмаа л ийм зарчимтай болгоё, мэргэшсэн болгоё, ойлгомжтой болгоё л гэсэн ийм зорилго юм. Гэхдээ мэдээж ойлгож байгаа. Таны саналыг бол сонслоо. Гэхдээ энэ бол ерөөсөө иргэдэд хамаатай биш бидний дотор энэ өргөдөл, гомдлоо яаж ангилах вэ, яаж архивлах вэ, ямар ажиллагаа хийснээ, ямар форматаар авах вэ гээд та бидний хамтдаа явсан нөгөө Германы Бундестагийнхаа загвар эд нарыг харж байгаад, тэр туршлагаасаа харж байгаад л хийсэн юм.

Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: Ойлголоо. Тэгэхээр энэ олон би харин тийм л юм яриад байгаа байхгүй юу. Дотроо дүрэмтэй бай, бид нар дотроо тангарагтай болох уу дараа нь? Энийгээ больчих оо хэрэггүй. Германы жишиг бид ба бэ-гүй хуулах албагүй. Бид нар ерөнхий зарчмаа ойлгосон шүү дээ. Тэгээд ингээд ийм бичиг цаас үйлдвэрлээд л, дүрэмтэй болоод л, журамтай болоод л ингээд байх тусмаа л хүнд суртал чинь нэмэгдээд л, чи дүрмийг зөрчсөн байна гээд л яах юм арга хэмжээ авах юм уу? Үгүй үгүй таны үзэмж болохгүй. Бид нар чинь олуулаа шийднэ. Байнгын хороон дарга тодорхой бас юутай шүү дээ энэ чинь эрх мэдэлтэй, тэрийгээ зөв хэрэгжүүл. Би таныг зөв хэрэгжүүлнэ гэдэгт 100 хувь найдаж байна.

Тэгэхээр энэ дүрэм, журмаа болио,. Энэний дараа яг тангарагтай болно шүү бид нар. Тэгээд дүрмээ зөрчсөн гишүүнийг яах юм арга хэмжээ авах юм уу? Ийм л юм болно. Бусдыг нь ойлгочихлоо, уучлаарай.

О.Номинчимэг: Дотоод зохион байгуулалтын юу. Тэгэхээр тэр санкц байхгүй. 1 хүнээс хамааралтай биш. Байнгын хороо 24 гишүүнтэй хамтын шийдвэр

гаргадаг байгууллага. Нэг хүнээс хамааралтай байж болохгүй тэр л зарчмаар гэж харж байгаа юм. Гэхдээ Мөнхбаясгалан гишүүний саналыг сонслоо.

Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: Мөнхбаясгалан гишүүнтэй эсрэг саналтай байна. Таны саналыг бас хүндэтгэж байна. Дүрэмтэй байх ёстой. Гэхдээ энэ ямар нэгэн байдлаар бид нарын үйл ажиллагааг хязгаарлах гээд байгаа зүйл байгаа агуулга биш байна. Зүгээр л нөгөө хуульд заачихсан байгаа Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн агуулгуудыг л тусгаад өгчихсөн байгаа. Тэгэхлээр энэнийхээ дагуу хэдүүлээ ажиллая л гэж байгаа. Тэгээд ямар нэгэн хариуцлага тооцно гэсэн зүйл энэ миний уншсанаар байхгүй байгаа учраас байсан нь зүгээр болов уу гэж бодож байна ийм дүрэмтэй байх нь. Энэ чинь дотоод зохион байгуулалтын л асуудал учраас.

Хамгийн сүүлд нь байгаа Өргөдлийн байнгын хорооны гишүүдийн хариуцах салбарын хуваарь гэж байгаа. Энэ дээр би өөрийнхөө орох салбараа хэлчихье. 2-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуй, хот байгуулалт, барилга, зам тээвэр, эрчим хүчний бодлогын асуудал дээр би орьё. Гэхдээ бусад ямар өргөдлүүд гарснаас хамаараад магадгүй 3 дээр байгаа хүний хөгжил, нийгмийн бодлогын асуудлын ажлын хэсэгт нь орох боломж нь бас нээлттэй тавьж өгөөсэй гэж хүсэж байна. Үүгээр нөгөө Мөнхбаясгалан гишүүн хайрцаглах гээд байгаа гэдэг дээр нь бол үүгээрээ битгий хайрцаглаасай гэж хүсэж байна. Ямар ч байсан 2 дээрээ орьё. Гэхдээ бусад рүү нь ч гэсэн орох боломжтой байдлаар та хэд минь шийдэж өгөөрэй гэж хүсэж байна.

Тэгээд хамгийн сүүлд нь байгаа энэ формат яг сая Номинчимэг даргын хэлж байгаагаар яг адилхан. Энэ танилцуулахдаа л ийм маягт ашиглая гэж байгаа болохоос биш бид нар заавал энийг ашиглаад иргэдээс энэ маягтын дагуу бөглөж өг өө гэсэн зүйл байхгүй шүү дээ.

Ганцхан асуулт байна. Надаас Өргөдлийн байнгын хороонд хандмаар байна яаж хандах вэ гэдэг асуултууд маш их ирж байна. Тэгээд Байнгын хорооны даргын зүгээс цахим юм уу, мэйл юм уу, эсвэл бичгээр юм уу, утсаар юм уу гэдэг зүйлийг тодорхой хариулаад өгөөсэй гэж хүсэж байна. Тэгээд Өргөдлийн байнгын хороо дэлхий дээр хамгийн сайн ажиллаж байгаа Өргөдлийн байнгын хороо Германы Бундестагийн байнгын хороо байгаа. Тэндээс нь бид нар энэ жишгийг нь бас авч болох зүйлийг нь авсан байгаа. Бүгдийг нь бол аваагүй байгаа шүү дээ энэ дээр чинь. Тэгэхлээр энэ зүйлүүдээ тусгаад тодорхой хэмжээний бусад Байнгын хорооноос дэвшилттэй байсан нь зүгээр гэж бодож байна. Мэдээж бусад Байнгын хороо ч гэсэн сая олон гишүүд хэлж байна тэгээд л асуудлыг хэлэлцээд л дүгнэлтээ гаргаад л ямар ч шийдэл байхгүй дуусчихдаг. Тэгэхлээр ямар нэгэн байдлаар бид нар ажил хийдэг Байнгын хороо байдаг юм шүү гэдэг зүйлийг бас харвал зүгээр гэж бодож байна.

Шийдэл гаргах дээр бол би энэ 3.3 дээр байгаа шаардлагатай бол холбогдох шийдвэрийн төслийн хамт гэж байгаа. Энэ нь бол тусчихсан байгаа гэж хараад байна. Тэгэхлээр шаардлагатай гэдгийг нь сая Б.Бат-Эрдэнэ гишүүн хэлж байсан. Заавал шийдэлтэй бай гэж хэлсэн болохлоор агуулгын хувьд харин засах хэрэг байгаа юм болов уу, үгүй юм болов уу? Найруулгын хувьд та бүхэн маань бас бусад гишүүдийнхээ саналыг тусгаад дараагийн Байнгын хороон дээр танилцуулаасай гэж хүсэж байна.

О.Номинчимэг: Тэгье. Энэ үг, үсэг дээр мэдээж бас та бүхнийхээ саналыг аваад ингээд тусгаад явна. Өргөдлийн байнгын хороонд яаж хандах боломжтой талаар Байнгын хорооны ажлын алба Наранцэцэг хариулах уу?

Д.Наранцэцэг: Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Өргөдлийн байнгын хороонд бичгээр, амаар, цахимаар хандах боломжтой. Мэдээж Байнгын хорооны даргын нэр дээр албан бичгээр өргөдөл, гомдол, хүсэлтийг ирүүлэх боломжтой. Түүнээс гадна Засгийн газрын 11-11 төвөөр бас манай 1 үйлчилгээний ажилтан өргөдөл, гомдол хүлээж авч байгаа. Гол нь өргөдөл, гомдлоо Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зүйл, заалтад заасан өргөдлийг буцаахгүйгээр хүлээж авах энэ шаардлагыг хангасан байх шаардлагатай. Цахимаар бас parliament.mn гээд бүх гишүүдийн манай Байнгын хорооны даргын болон гишүүдийн и-мэйлээр бас ирүүлэх боломжтой.

О.Номинчимэг: Лувсанжамц гишүүн тодруулъя.

Г.Лувсанжамц: Бичгээр болон цахимаар гэж байгаагаа цахим гэдэг нь гишүүний мэйл хаяг руу парламент цэг мэйл хаяг руу явуулсныг тооцно гэж байгаа юу? Эсвэл Өргөдлийн байнгын хорооны тусдаа цахим хаяг байгаа юу? Бичгээр гэж байгаа тохиолдолд ордонд авчирч өгөх юм уу, шуудангаар явуулах юм уу? Хаяглахдаа юу гэж хаяглах вэ, хэнд хаяглах вэ гэдгийг нь бас тодорхой хэлж өгвөл зүгээр болов уу.

О.Номинчимэг: Наранцэцэг ахлахын микрофоныг өгье.

Д.Наранцэцэг: Бичгээр бол шуудангаар болон ордны бас өргөдөл, гомдол хүлээж авах хайрцагт бас хийх боломжтой. Шуудангаар бол мэдээж Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороонд гэдгээр хаяглаж ирүүлэх боломжтой.

Цахимаар бол Байнгын хороо одоогоор арай цахим хаяггүй байна. Би энэ асуудлыг бас мэдээлэл технологийн газарт хэлж Байнгын хорооны цахим хаяг бий болгоё. Сошиал цахимаар бол Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороо гэсэн цахим хаяг бас ажиллаж байгаа. Манай олон нийттэй харилцах ажилтан бас энийг ажиллуулж байгаа.

О.Номинчимэг: Гишүүддээ баярлалаа. Өнөөдрийн хэлэлцэх асуудал ингээд дуусаж байна. Ингээд энэний дүрмийн асуудал цөмөөрөө яаж энийгээ бас үр дүнтэй зохион байгуулах вэ гэдгийг цаашдаа үргэлжлүүлж бас та бүхэнтэйгээ ярина.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан хаасныг мэдье мэдэгдье. Та бүхэнд баярлалаа.

11.35 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

